

БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ


Mongolian
Economy

www.mongolianeconomy.mn

№02



БҮСЧИЛСЭН
ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН



ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ШИНЭ ЗАГВАР

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Хойд бүсийн хөгжлийн
тулгуур аялал жуулчлал

МЕГА ТӨСӨЛ

Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийн
ирээдүйн хөгжлийг тодорхойлно

БҮСЧЛЭЛИЙН ТОГТОЛЦОО ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

ХОЙД БҮС

БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС

БАРУУН БҮС

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨРӨЛЖСӨН,
БАЙГАЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮС

ХАНГАЙН БҮС

УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙН ТӨРӨЛЖСӨН,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭД БҮС

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ
64 ДҮГЭЭР ТОГТООЛООР "БҮСЧИЛСЭН
ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ"-ЫГ
ШИНЭЧЛЭН БАТЛАВ.

ТӨВИЙН БҮС

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨРӨЛЖСӨН,
АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС

ЗҮҮН БҮС

ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН,
ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭД БҮС






УЛААНБААТАРЫН БҮС

ОЛОН УЛСЫН БАНК, САНХҮҮ,
БИЗНЕСИЙН ХӨГЖЛИЙН БҮС НУТАГ

ГОВИЙН БҮС

АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨРӨЛЖСӨН,
НОГООН ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД БҮС

Агуулга



05 РЕДАКЦЫН ЗУРВАС

Хойд бүсийн хөгжлийн шинэ загвартай танилцана уу

06 МЭНДЧИЛГЭЭ

Бүсийн хөгжил улсын хөгжлийг хөтөлнө

07 МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн реформыг таван шинэтгэлийн хүрээнд эхлүүлнэ

08 ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн судлагдсан байдал

10 ОНЦЛОХ НИЙТЛЭЛ

Хойд бүсийн хөгжлийн бодлого хөгжлийн шинэ загвар

12 ОНЦЛОХ ЯРИЛЦЛАГА

Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуяг: Хойд бүс бол байгаль, үйлдвэр, дэд бүтцийг уялдуулсан хөгжлийн шинэ эхлэл

16 ТООН МЭДЭЭЛЭЛ

18 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Хойд бүсийн хөгжлийн тулгуур аялал жуулчлал

20 ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

Хойд бүсийн бизнесийн идэвхжил

22 БОДЛОГЫН БАЙР СУУРЬ

26 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

30 ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Д.Эрдэнэбаяр: Хойд бүс бол Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг тэтгэх стратегийн бүс

34 МЕГА ТӨСӨЛ

Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийн ирээдүйн хөгжлийг тодорхойлно

36 ХОЙД БҮС

44 БУЛГАН АЙМАГ

48 ОРХОН АЙМАГ

52 ХӨВСГӨЛ АЙМАГ

56 ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛ

Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан

58 БОДЛОГО

Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэр

60 БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ: Д.БЭХБАЯР (9999 4248) | РЕДАКТОР: Н.ЭНХБАЯР | АНГЛИ РЕДАКТОР: РОБЕРТ ЙОХАН ШРАЙВЕРС | СЭТГҮҮЛЧИД: У.САРАНГЭРЭЛ | Б.ШҮРЭНЧИМЭГ | ДИЗАЙНЕР: Ш.ОЮУНДАРЬ | Б.ТЭРГЭЛ

ХАМТРАГЧ БАЙГУУЛАГА:



МАРКЕТИНГИЙН АЛБА: 8988 2899

ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ШИНЭ ЗАГВАРТАЙ ТАНИЛЦАНА УЧ



“Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс Монгол Улсаа бүсчлэн хөгжүүлэх санаачилгыг дэмжиж, энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд олон нийтэд мэдээллийн платформын үүрэг гүйцэтгэн ажиллахаа илэрхийлснээр “Бүсчилсэн Хөгжил” дагнасан сэтгүүлийг бий болгосон билээ. Бид “Монгол Улсын хөгжлийн шинэ загвар” гарчигтай анхны дугаараа 2025 онд гаргасан бөгөөд Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын талаар тодорхой мэдээлэл өгсөн. Тодруулбал, Бүсчилсэн хөгжил гэж юуг хэлж байгаа, хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, бүсүүдийн хөгжлийн газарзүйн онцлог, ялгаа, төсөл хөтөлбөрүүд, бүтээн байгуулалтууд, хэрхэн хөрөнгө оруулалт татах зэрэг агуулгыг багтаасан юм.

Харин энэ удаа Хойд бүсийн хөгжлийн зорилго төлөвлөгөө болон тус бүс хэрхэн хөгжих талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх юм. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл аймаг багтдаг. Тус бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс, “Аж үйлдвэрийн дэд бүс”

болох юм.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн дөрвөн чиглэлийн 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгаснаас Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц, Зэс боловсруулах цогцолборын төслүүд Хойд бүсэд хэрэгжинэ. Эдгээр төсөл амжилттай хэрэгжсэнээр Хойд бүсийн хөгжлийн хурдасгуур болж, аж үйлдвэрийн салбарын өсөлтийг бий болгох юм. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд газар зүйн байрлал, байгалийн нөхцөл, нөөц, дэд бүтцийн хөгжил зэргийн онцлогийг харгалзан өөр бусад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгаад байгаа юм. Тодруулбал, байгалийн аялал жуулчлалын үнэт нөөц, аж үйлдвэрийн суурь, стратегийн хил орчмын байршлыг уялдуулан хөгжүүлэх замаар тус бүсийг улс орны эдийн засгийн шинэ тулгуур болгохоор зорьж буй.

“Бүсчилсэн хөгжил” сэтгүүлийн “Хойд бүсийн хөгжлийн шинэ загвар” дугаарыг та бүхэнд хүргэж байна.

Бүсчилсэн хөгжил сэтгүүлийн редакц

БҮСИЙН ХӨГЖИЛ УЛСЫН ХӨГЖЛИЙГ ХӨТӨЛНӨ



Хойд бүсийн тэргүүлэх чиглэлийг Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс байхаар Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан.

Энэхүү баримт бичигт бүс, орон нутгийн хөгжлийн ялгааг багасгаж, эдийн засгийн хувьд төрөлжүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх замаар орон нутгийн хөгжлийн үзүүлэлтийг 20 хувиар нэмэгдүүлэх зорилтыг тавив.

Зүг чиг зөв бол хүрэх газар дөт гэж үгтэй. Монгол Улсыг 2026-2030 он хөгжүүлэх Үндсэн чиглэлийг УИХ баталснаар хөгжлийн зүг чиг тодорхой болж чадлаа. Гагцхүү хөгжлийн баримт бичгээ хэрэгжүүлж, үр дүнд хүрэх нь чухал юм.

“Шинэ итгэл-Эрс шинэтгэл”-ийг гол зорилгоо болгосон Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8 бодлогын зорилтын нэг нь “Бүсийн хөгжил” юм. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлснээр Монгол Улс хөгжлийн цэгцрэх хөдөлгөөн өрнөж байна.

Бид төвлөрлийг сааруулах ёстой. Улсын төсөв зөвхөн үндэсний хэмжээний мега төслүүдээ санхүүжүүлдэг болно. Харин тухайн орон нутгийн хөгжлийн асуудлыг орон нутаг өөрөө шийддэг, төсвийн бие даасан байдлыг нь нэмэгдүүлсэн, мөнгөний эрх мэдлийг нь шилжүүлсэн жинхэнэ реформыг бид хийнэ.

Хойд бүсийн хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай гол түүхий эд болох мах 82.8 мян. тн, сүү 26.0 мян.тн, ноос 4.5 мян.тн, ноолуур 1.1 мян.тн, арьс шир 2.8 сая ширхгийг тус тус бэлтгэн зах зээлд нийлүүлсэн байна. Цаашид хөдөө аж ахуйн салбарт судалгаанд суурилсан шинжлэх ухааны оролцоотой үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй. Монгол Улс үйлдвэрлэлийг хөгжүүлэх хамгийн давуу тал нь органик хүнс. Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд нэн

тэргүүнд хэрэгжүүлэх төслүүдийн саналыг салбарын яамд, орон нутгаас авч, саналыг нэгтгэн, эрэмбэлж дараах 5 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- *Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барих (Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сум);*
- *Мөрөн нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөж, олон улсын нислэг хүлээн авах боломжийг судална. (Хөвсгөл);*
- *Эгийн голын усан цахилгаан станц барина. (Булган аймаг, Хутаг-Өндөр сум);*
- *Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, бүсүүдэд дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна. (Хөвсгөл, Булган аймаг);*
- *ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль болон Мэдээлэл холбооны технологийн сургуулийг Орхон аймагт шилжүүлэх. (Орхон аймаг)*

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд 7 бүсийн тогтолцоотой болсны дагуу бүс бүрд бүсийн зөвлөлийг байгуулсан юм. Бүсийн зөвлөлийн даргын бүрэн эрхийг тус бүсэд багтах аймгийн Засаг дарга нар ээлжлэн хэрэгжүүлнэ. Мөн Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг тухайн бүсэд хамаарах аймгуудад жил бүр ээлжлэн зохион байгуулахаар төлөвлөж байна.

Бүс нутгийн хөгжил улс орны хөгжлийг тэргүүлнэ. Бүсийн хөгжилд иргэн бүрийн оролцоо, хандлага, хичээл зүтгэл хамгаас чухал.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН РЕФОРМЫГ ТАВАН ШИНЭТГЭЛИЙН ХҮРЭЭНД ЭХЛҮҮЛНЭ



Эрхэм хүндэт уншигчид аа!

Монгол Улсын Засгийн газраас “Шинэ итгэл, эрс шинэтгэл” цогц реформыг дэвшүүлсэн бөгөөд Бүсийн хөгжлийн реформ үүнд багтаж байгаа юм.

Засгийн газрын дэвшүүлсэн цогц реформыг хэрэгжүүлэх зорилгоор бүсчилсэн хөгжлийн бодлогыг бодит ажил, тодорхой үр дүнд чиглүүлэн олон ажил санаачлан хэрэгжүүлж байна. УИХ-ын 2024 онд баталсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” нь бүс бүрийн давуу талд тулгуурласан тэнцвэртэй, тогтвортой хөгжлийн тогтолцоонд шилжүүлэх суурь баримт бичиг болсон.

Энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухайхууль”-днэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохион байгуулалт, бүсийн зөвлөл, түүний бүрэлдэхүүнийг оновчтой тодорхойлж, жил бүрийн Улсын төсвийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцоонд шилжүүлэх зохицуулалтуудыг бий болгох чиглэлээр ажиллаж байна.

Түүнчлэн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын хэрэгжилтийг хангахад чиглэсэн “Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулах ажлыг эхлүүлээ. Энэ хүрээнд аймаг, орон нутгийн байгалийн нөхцөл нөөц, онцлог, давуу талд тулгуурлан эдийн засгийн чиг үүргийг тодорхойлж, түүнд чиглэгдсэн төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үр өгөөжтэй хамтран хэрэгжүүлж, бүсийн нийгэм, эдийн засгийн өсөлт хангагдан харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Тус бодлогын баримт бичигтэй уялдуулан аймаг, орон нутаг дунд, богино хугацааны хөгжлийн бодлогоо боловсруулж, улсын,

бүсийн, орон нутгийн түвшинд бодлогын уялдаа хангагдах юм. Тухайлбал, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн зорилтот хөтөлбөр, орон нутгийн бодлого, төлөвлөлт гэсэн гурван түвшний бодлого цогц, уялдаатай тодорхойлогдож улс, орон нэг зүгт харж хөгжих нөхцөл бүрэлдлээ. Ингэснээр бүсийн хөгжлийг дэмжих томоохон ач холбогдолтой бүтээн байгуулалтын төслүүд гурван түвшний бодлогын баримт бичгүүдэд тусгагдан хэрэгжих юм.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хамгийн гол зорилго чиглэл бол аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг борлуулалтаар нь дэмжих, дотоод гадаадын зах зээлд холбон бизнес, хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бий болгож, бүсүүдийг бие даан хөгжих эдийн засгийн чадавхтай болгоход чиглэнэ. Ингэснээр хот, хөдөөгийн ялгаа бодитоор багасаж, иргэдийн амьдралын чанар сайжирна.

Энэхүү бодлого нь “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй бүрэн уялдсан үндэсний хэмжээний бодлого юм. Бүсчилсэн хөгжил бол зөвхөн төрийн ажил бус, хувийн хэвшил, орон нутаг, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан амжилтад хүрэх стратеги билээ.

Бид хамтдаа бүсчилсэн хөгжлийн шинэ үеийг эхлүүлж, Монгол Улсын тогтвортой, тэнцвэртэй өсөлтийн бат бөх суурийг тавина гэдэгт итгэлтэй байна.

Уншигч Та бүхэнд амжилт, бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
ХАССУУРИЙН ГАНХУЯГ**

МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН



И.Х.ОВДИЕНКОГ-ИЙН
БОЛОВСРУУЛСАН
ЭДИЙН ЗАСГИЙН
МУЖЛАЛЫН СХЕМ



ОЛНОО ӨРГӨГДСӨН
МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН
ЗАСАГ ЗАХИРГАА НУТАГ
ДЭВСГЭРИЙН ХУВААРЬ



Д.ДАНДАРБААТАР,
Д.САЙН-ЭР НАРЫН
ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН
ЗАСГИЙН БҮСЧЛЭЛ

1919

1967


1997

1961

1969

1997

П.А.АЛАМПИЕВ, Ч.СЭРЭЭТЭР
НАРЫН БОЛОВСРУУЛСАН ЭДИЙН
ЗАСГИЙН МУЖЛАЛЫН СХЕМ



М.ЭНХСАЙХАНЫ
ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН
ЗАСГИЙН БҮСЧЛЭЛ



Б.ГУНГААДАШИЙН
БОЛОВСРУУЛСАН
“ЭДИЙН ЗАСГИЙН
МУЖ”-ИЙН ЗУРАГЛАЛ



СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх хүрээнд Олноо өргөгдсөн Монгол Улсын үеэс хэд хэдэн хувилбарыг дэвшүүлэн санал болгож байсан. УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар Хойд бүсийг бүрдүүлж буй Булган, Орхон, Хөвсгөл аймгууд нь ихэнх тохиолдолд нэг бүсэд хамаарч ирсэн байна.



МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭНД БАТЛАГДСАН "ЭДИЙН ЗАСГИЙН МУЖ"

2001



Ц.СҮХБААТАРЫН ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧЛЭЛИЙН ЗАГВАР

2018

2011

АРДЧИЛСАН НАМ "МОНГОЛ ХҮН-2020" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧЛЭЛ



2020



Р.РИНЧИНБАЗАР, Д.ЭРДЭНЭБАЯР НАРЫН ДЭВШҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСГИЙН БҮСЧЛЭЛИЙН ЗАГВАР

ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ШИНЭ ЗАГВАР



ХОЙД БҮСЭД ХЭРЭГЖИХ ХОЁР МЕГА ТӨСӨЛ
НЬ ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР БОЛЖ, АЖ
ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨСӨЛТИЙГ БИЙ
БОЛГОХОД АЧ ТУСАА ӨГНӨ.



Дэлхийн улс орнуудын хөгжлийн онолд өөрчлөлт орж, бүсчилсэн хөгжлийн загварыг чухалчлан үзэх болжээ. Учир нь улс орон бүр өөр өөрийн газар нутгийн онцлог түүх, соёл, үнэт зүйлсийн өвтэй. Сэтгэлгээний хүрээлэл ч өөр. Тийм учраас нэг загварт цутгасан бодлогоор бус улс орнууд тэрхүү өөрийн гэсэн онцлогоо гаргаж ирж, түүн дээрээ тулгуурлан хөгжлийн бодлогоо явуулах ёстой гэсэн онол илүү жин дарах болжээ. Өөрөөр хэлбэл, газар нутаг, хүн амын байршил, баялгийн нөөц дээрээ үндэслэн бүсчилсэн байдлаар хөгжих нь хамгийн зөв бодлого юм гэж үзэх болсон байна. Монгол Улсын хувьд энэхүү хөгжлийн онол дэлхий дахинаа хүчтэй дэлгэрсэн үеэс 20 жилийн дараа буюу 2001 онд бүсчилсэн хөгжлийн бодлогыг баталсан байдаг. Гэхдээ дорвитой хэрэгжээгүй. Харин 25 жилийн дараа буюу 2024 онд Монгол Улс бүсчлэн хөгжинө гэдэг дээрээ багтай зогсож, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг УИХ-аас баталсан. Ийм бодлогын баримт бичигтэй болсноор “Монгол Улсын цаашдын

хөгжил бол бүсчилсэн хөгжил” гэдгээ тодорхой болгож, санал нэгдэв. Улс төрийн намууд ч, эдийн засаг, бизнес, эрдэмтэн докторууд бүгд санал нэгдэж, хөгжлийн чиглэлээ тодорхойллоо. Одоо монголчууд бид ирээдүйн хөгжлийн чиг, луужинтай болж, нэг зүгт харж явах бодлогын баримт бичигтэй болсон гэсэн үг.

Яагаад бүсчлэн хөгжье гэж?

Хүн амын өсөлт 2024 онд Улаанбаатар хотод 1.9 хувь, орон нутагт 0,4 хувь байна. ДНБ нийслэлд 70 хувь, орон нутагт 30 хувь, ядуурал нийслэлд 21,6, орон нутагт 30 хувь байна. Худалдаа үйлчилгээний хувьд нийслэлд 79 хувь, орон нутагт 21 хувь, их дээд сургууль хотод 96, хөдөөд 4 хувь. Энэ тоон үзүүлэлтүүд манай улсын хөгжлийн бодит байдлыг

тод харуулна. Улаанбаатар хотын хөгжлийн, амьдралын даац хэтэрснийг нотолж байна. Хөдөө орон нутагт хүн ам сийрэгшиж, хөгжил 1.5 жилээр хоцрогдсон гэсэн тоог онцолъё.

Хойд бүс

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар Хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл аймгууд багтдаг. Бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд “Аж үйлдвэрийн дэд бүс” болно. Булган аймгийн Булган, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Орхон аймгийн

БУЛГАН АЙМАГ



Баян-Өндөр, Хөвсгөл аймгийн Мөрөн, Рэнчинлхүмбэ, Хатгал / Алаг-Эрдэнэ/, Тариалан, Галт, Цагаан-Уул гэсэн 11 орон нутгийн хөгжлийн төв бий.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн дөрвөн чиглэлийн 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгаснаас Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц, Зэс боловсруулах цогцолборын төслүүд тус тус Хойд бүсэд хэрэгжинэ. Эдгээр төслүүд амжилттай хэрэгжсэнээр Хойд бүсийн хөгжлийн хурдасгуур болж, аж үйлдвэрийн салбарын өсөлтийг бий болгоно. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд газар зүйн байрлал, байгалийн нөхцөл, нөөц, дэд бүтцийн хөгжил зэргийн онцлогийг харгалзан өөр бусад төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Булган аймагт Засгийн газрын хэрэгжүүлэх 14 мега төслийн нэг Эгийн голийн эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын төсөл хэрэгжинэ. Мөн Булган аймаг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, газар тариалангийн хөгжлөөр улсдаа гуравт ордог. Цаашид хөдөө аж ахуйн төрөлжсөн үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах боломжтой.

ХӨВСГӨЛ АЙМАГ



Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодын үйл ажиллагааг дэмжих, бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

Аялал жуулчлал бол хойд бүсийн хөгжлийн тулгуур төдийгүй Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн гол цэгүүдийн нэг юм. Хойд бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг болон "Цэнхэр сувд" байгалийн шинжлэх ухааны музейн цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна. Аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих хүрээнд Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөх, Ханх боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Ханх боомт-Хатгал тосгон болон Мөрөн хот-Тэлмэн сум чиглэлийн босоо тэнхлэгийн авто замыг барьж ашиглалтад оруулна.

Мөн бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан

ОРХОН АЙМАГ



аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Хөвсгөл, Булган аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

2024 оны эцэст хойд бүсийн хүн амын тоо 308.7 мянгад хүрч Монгол Улсын нийт хүн амын 8.7 хувийг бүрдүүлж байна. Орхон аймагт зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бөгөөд газар зүйн байршил, суурь дэд бүтцэд тулгуурлан бүсийн тээвэр, логистикийн төв болон хөгжинө. Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд Аж үйлдвэрийн дэд бүс болон хөгжих хүрээнд Орхон аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг байгуулна. Хүн амын төвлөрөл, түүнийг дагасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлтийг хангах зорилгоор бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, осол гэмтлийн болон мэс заслын тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлэн хөгжүүлнэ. Мөн бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

Онцлох ярилцлага

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Х.ГАНХУЯГ:

**ХОЙД БҮС БОЛ
БАЙГАЛЬ, ҮЙЛДВЭР,
ДЭД БҮТЦИЙГ УЯЛДУУЛСАН
ХӨГЖЛИЙН ШИНЭ ЭХЛЭЛ**

Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэн бүсчилсэн хөгжлийг цаасан дээрх төлөвлөлтөөс бодит ажил, хэрэгжилтийн шатанд шилжүүлж байгаа билээ. Энэ бодлогын хамгийн тод жишээ нь Хойд бүс юм. Байгалийн аялал жуулчлалын үнэт нөөц, аж үйлдвэрийн суурь, стратегийн хил орчмын байршилг уялдуулан хөгжүүлэх замаар тус бүсийг улс орны эдийн засгийн шинэ тулгуур болгохоор зорьж буй талаар УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуягтай ярилцлаа.

-Бүсчилсэн хөгжлийн бодлого олон жил яригдсан сэдэв. Харин өнөөдөр үүнийг бодит хэрэгжилтийн шатанд орлоо гэж үзэж болох уу?

-Тийм ээ. Өнөөдөр бид бүсчилсэн хөгжлийг цаасан дээрх төлөвлөгөө, судалгаанаас бодит ажил, хэрэгжилтийн шатанд шилжүүлсэн байна. Өмнө нь энэ бодлого ихэвчлэн үзэл баримтлал, судалгааны түвшинд яригддаг байсан бол одоо бодлогын баримт бичгүүд батлагдаж, бүс бүрд чиглэсэн тодорхой төсөл, хөрөнгө оруулалт, хугацаатай төлөвлөгөөнүүд хэрэгжиж эхэллээ. Бид “энэ бүс ямар чиглэлээр хөгжих вэ, ямар онцлог, давуу тал дээр тулгуурлах вэ” гэсэн асуултад тодорхой хариулт өгсөн. Өөрөөр хэлбэл, Байгалийн аялал жуулчлалын үнэт нөөц, аж үйлдвэрийн суурь ба стратегийн хил орчмын байршил, дэд бүтцийн төлөвлөлт, боловсруулах үйлдвэрлэл, ложистикийн сүлжээ зэргийг уялдуулан бодит, хэрэгжүүлэх боломжтой төсөл, загваруудыг боловсруулсан гэсэн үг. Энэ нь зөвхөн зорилго, уриалга биш, тодорхой хугацаатай, санхүүжилттэй төлөвлөгөө юм. Үүний үр дүнд Хойд бүсийг Монгол Улсын эдийн засгийн

шинэ тулгуур болгох алхам хийж байна.

-Засгийн газраас хойд бүсийн хөгжлийг төлөвлөхдөө ямар үндсэн зарчим, үзэл баримтлалыг гол болгож байна вэ. Тухайлбал, байгаль хамгаалал, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьжиргаа зэрэг олон талын шаардлагыг хэрхэн уялдуулж байна?

-Монгол Улсын Засгийн газраас баримталж буй гол зарчим бол тэнцвэртэй хөгжил. Өөрөөр хэлбэл, байгаль хамгаалал, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьжиргаа хоорондоо зөрчилдөх ёсгүй, харин бие биеэ дэмжих ёстой. Жишээлбэл, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газар бол Монголын төдийгүй бүс нутгийн хэмжээнд ч нөхөж баршгүй үнэт баялаг. Үүнийг хамгаалахгүйгээр урт хугацааны хөгжил ярих боломжгүй. Тиймээс аялал жуулчлал, үйлдвэржилтийг байгальд ээлтэй технологи, тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурлан уялдуулах бодлого барьж байна. Одоогоор Хойд бүсийн ДНБ-ий 63.7 хувийг үйлдвэрлэл эзэлж байна. Энэ нь томоохон давуу тал. Гэхдээ үйлдвэрлэл цаашид илүү өндөр нэмүү өртөг шингэсэн, боловсруулалтын шат ахисан байх ёстой. Жишээлбэл, Орхон аймагт байгуулагдах зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр нь зөвхөн нэг аж ахуйн нэгж биш, харин бүс нутгийн ханган нийлүүлэлт, тээвэр, ложистик, засвар үйлчилгээ, мэргэжлийн ажиллах хүчний эрэлт нэмэгдэх боломжийг бий болгох юм. Ингэснээр Хойд бүсийн эдийн засаг нэг салбараас хэт хамааралгүй, илүү төрөлжсөн бүтэцтэй болж, байгаль хамгаалал, үйлдвэрлэл, иргэдийн амьжиргаа гурвыг нэгэн зэрэг хөгжүүлэх тэнцвэртэй бодлого хэрэгжиж байна.

-Хойд бүсийн хил орчмын байршил эдийн засгийн бодлогод ямар ач холбогдолтой вэ?

-Булган, Хөвсгөл аймаг ОХУ-тай хиллэдэг нь стратегийн томоохон давуу тал. Энэ нь зөвхөн экспорт, импортын асуудал биш, харин тээвэр, логистик, аялал жуулчлал, бүс нутгийн хамтын ажиллагааны өргөн боломж юм. Ханх, Бага-Илэнх боомтуудыг өргөтгөж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, авто болон төмөр замын сүлжээг шинэчлэх нь Хойд бүсийг хойд чиглэлийн эдийн засгийн гол гарц болгоно. Улаанбаатар-Хархорум чиглэлийн авто болон төмөр замын бүтээн байгуулалтууд ч энэ зорилготой уялдаж байгаа.

Хойд бүсийг Монгол Улсын эдийн засгийн шинэ тулгуур болгох алхмыг хийж байна

-Өнгөрсөн хавар Булган аймагт зохион байгуулсан Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаанаар Засгийн газар ямар томоохон шийдвэрүүдийг гаргасан бэ. Тэдгээрийн ач холбогдол юу байсан бэ?

-Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан бол “бүсчилсэн хөгжил цаасан дээр биш, газар дээрээ хэрэгжиж эхэллээ” гэдгийг харуулсан чухал үйл явдал болсон. Булган аймагт Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдсанаар Хойд бүсийн хөгжлийн асуудлыг салбар салбараар нь нэг дор, уялдаатай шийдэх бодит боломж бүрдсэн. Энэ хурлаар хэд хэдэн томоохон, зарчмын

шийдвэр гаргасан. Нэгдүгээрт, Хойд бүсийн дэд бүтцийн суурь төслүүдийг улсын хөрөнгө оруулалтын бодлогын тэргүүлэх чиглэлд албан ёсоор оруулсан. Тухайлбал, Ханх, Бага-Илэнх боомтын өргөтгөл, тэдгээрийг холбосон авто зам, цаашлаад төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг яаралтай боловсруулах шийдвэр гаргасан. Хоёрдугаарт, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх тусгай бүсчлэл, зохицуулалтыг Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газарт хэрэгжүүлэх чиглэл өгсөн. Энэ нь аялал жуулчлалыг дур зоргоор нь тэлэх биш, байгаль хамгаалалтай уялдуулсан, чанарт суурилсан загвараар хөгжүүлэх эхлэл юм. Гуравдугаарт, үйлдвэрлэл, ялангуяа боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих бодит механизмуудыг баталсан. Орхон, Булган аймагт хэрэгжих томоохон үйлдвэрүүдийг дагасан инженерийн дэд бүтэц, мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэх, жижиг дунд бизнесийг ханган нийлүүлэлтийн сүлжээнд оруулах асуудлыг салбар яамд хариуцан хэрэгжүүлэхээр болсон. Хамгийн чухал нь, эдгээр шийдвэрүүд тодорхой хариуцагч, хугацаа, санхүүжилтийн эх үүсвэртэйгээр батлагдсан. Өөрөөр хэлбэл, “хийе” гэсэн ерөнхий урианаас “хэзээ, хэн, яаж” гэдэг бодит шатанд орсон гэсэн үг. Энэ бол Хойд бүсийн хувьд төдийгүй Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогын хувьд шинэ эхлэл гэж харж байна.

-Хойд бүсийн онцлог нь байгалийн аялал жуулчлалын хөгжлийг дэмжих явдал юм. Тухайлбал, Хөвсгөл аймаг бусад аймгаас аялал жуулчлалаараа давуу байр суурьтай. Энэ салбарыг бодлогын түвшинд хөгжүүлэх замаар орон нутгийн иргэдэд ямар бодит үр өгөөж үзүүлэх боломжтой вэ?
-Аялал жуулчлал бол зөвхөн



жуулчин ирэх тухай ойлголт биш. Энэ нь орон нутгийн иргэдийн орлого, жижиг, дунд бизнес, үйлчилгээний салбарыг шууд дэмждэг, эдийн засгийн хөдөлгөгч хүч юм. Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалыг улирлын чанартай бус, дөрвөн улирлын тогтвортой салбар болгон хөгжүүлэх зорилт тавьж байна. Үүний тулд нисэх буудлыг олон улсын 4С ангилалд хүргэж, зам тээврийн дэд бүтцийг сайжруулах, мөн “Цэнхэр сувд” байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулж, орон нутгийн соёл, байгаль, аялал жуулчлалыг нэгтгэсэн бүтээлч төв болгох

зэрэг төлөвлөгөө боловсруулсан. Ингэснээр аялал жуулчлалын салбарын хөгжлийг орон нутгийн иргэдийн амьдралд шууд, бодит үр дүнтэйгээр мэдрүүлж, орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжих, ажлын байр бий болгох, амьдралын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруула гэж харж байгаа.

-Тэгвэл хойд бүсийг хөгжүүлэхэд эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүд ямар үүрэг гүйцэтгэх вэ. Тэдгээр нь бүсийн эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, логистик болон орон нутгийн иргэдийн

амьжиргаанд хэрхэн нөлөөлөх бол?

-Эрчим хүч бол аливаа бүс нутгийн хөгжлийн суурь хүчин бөгөөд хэрэв тогтвортой, найдвартай эх үүсвэр байхгүй бол үйлдвэрлэл, дэд бүтэц, үйлчилгээний салбарууд хөгжих боломжгүй юм. Өнөөдөр Хойд бүсэд хэрэгжиж буй томоохон төсөл бол Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц юм. Энэ станц ашиглалтад орсноор зөвхөн Хойд бүс төдийгүй Монгол Улсын хэмжээнд эрчим хүчний тогтвортой эх үүсвэр нэмэгдэж, аж үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжих боломж бүрдэнэ. Мөн Эрдэнэт хотод байгуулагдах тээвэр, логистикийн төв нь үйлдвэрлэл, худалдааны урсгалыг нэг дор төвлөрүүлэх, бүс нутгийн хэмжээнд стратегийн ач холбогдол бүхий зангилаа болох юм. Ингэснээр Хойд бүс нь зөвхөн үйлдвэрлэлийн суурь аймаг төдийгүй улс орны эдийн засгийн хязгааргүй боломжийг ашиглах төв болох бөгөөд дэд бүтцийн сайжруулалт нь ажлын байр бий болгох, бизнесийн орчныг сайжруулах, орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд шууд нөлөө үзүүлнэ. Иймд эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүд нь зөвхөн техник, бүтээн байгуулалт төдийгүй бүсийн эдийн засгийн тогтвортой өсөлт, төрөлжсөн үйлдвэрлэл, аялал жуулчлал, логистикийн сүлжээг хөгжүүлэх гол хөдөлгөгч хүч юм.

-Хойд бүсийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, боловсролын бодлого ямар үүрэг гүйцэтгэх вэ. Мөн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжид ямар өөрчлөлт гарах бол. Үүнийг бодлогын түвшинд хэрхэн зохицуулж байна вэ?

-Хойд бүсийн хөгжлийг зөвхөн дэд бүтэц, үйлдвэрлэлийн төслөөр хэмжихгүй. Томоохон төслүүд

хэрэгтэй ч тэдгээрийг ажиллуулах чадвартай, мэргэжлийн хүмүүс илүү чухал. Иймээс хүний нөөц, боловсролын бодлогыг бүсийн эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. Жишээ нь, Орхон аймагт байгуулагдах “Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор” нь аж үйлдвэртэй шууд холбоотой мэргэжилтэн бэлтгэх загвар болно. Хөвсгөл, Булган аймагт байгуулагдах дадлага, үйлдвэрлэлийн баазууд ч мэргэжилтэй ажиллах хүчийг бэлтгэх, орон нутгийн иргэдийг ажлын байранд бэлтгэх зорилготой. Ийнхүү боловсрол, мэргэжлийн сургалт нь бүсийн эдийн засгийн бодлоготой уялдсан, тогтвортой хөгжлийн үндэс болно. Мөн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч байна. Бүсийн хэмжээнд оношилгоо, эмчилгээ, мэс заслын тусламжийг төрөлжүүлснээр иргэд заавал нийслэл зорих шаардлага багасна. Орхон аймагт эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулах, Хөвсгөл аймагт халдварт өвчний бэлэн байдлын дэд төв байгуулах зэрэг арга хэмжээнүүд төлөвлөгдсөн. Энэ бүх бодлого, дэд бүтцийн шинэчлэл, хүний нөөцийн хөгжлийн ажил нь өнгөрсөн хавар зохион байгуулагдсан Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралд тодорхой шийдвэр болон батлагдсан.

-Та Хойд бүсийн хөгжлийн ирээдүйд хэрхэн төсөөлж байна вэ. Бүсийн байгалийн нөөц, үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлалын хоорондын уялдаа ирээдүйд ямар үр дүнд хүрч болох талаар та хэрхэн харж байна вэ?

-Хойд бүсийг байгаль хамгаалал,


аж үйлдвэр, дэд бүтэц, аялал жуулчлалыг харилцан уялдуулсан, тогтвортой хөгжлийн жишиг бүс болгон хөгжүүлэх чиглэл баримталж байна. Байгалийн үнэт баялгийг хамгаалахтай зэрэгцэн нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэл, стратегийн ач холбогдол бүхий логистик төвүүдийг хөгжүүлэх, хил орчмын байршлын давуу талыг эдийн засгийн боломж

Хойд бүсийн хөгжлийг зөвхөн дэд бүтэц, үйлдвэрлэлийн төслөөр хэмжихгүй


болгон ашиглах чиглэлд бодлого, төлөвлөлт хийгдэж байгаа. Энэ хүрээнд иргэдийг тогтвортой орлоготой ажлын байраар хангах, чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг орон нутагтаа хүртэх нөхцөлийг бүрдүүлэх, залуусын хот руу чиглэсэн шилжилтийг бууруулж, нутагтаа ажиллаж амьдрах боломжийг нэмэгдүүлэх зорилтыг Монгол Улсын Засгийн газар дэвшүүлэн ажиллаж байна. Цаашид Хойд бүсийн эдийн засгийг нэг салбараас хэт хамааралгүй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, логистик зэрэг олон тулгуурт, төрөлжсөн бүтэцтэй байхаар хөгжүүлэх нь орон нутгийн хөгжлийг улсын эдийн засгийн бодит хувь нэмэр болгох боломжтой гэж харж байна. Энэ утгаараа Хойд бүсийн хөгжил нь зөвхөн тухайн нутгийн хэмжээнд хязгаарлагдахгүй, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогыг бодит ажил, үр дүнгээр илэрхийлэх, урт хугацааны тогтвортой хөгжлийн нэгэн чухал жишээ болох боломжтой юм.

Тоон мэдээлэл


ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН /САЯ ТӨГРӨГ/




ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО



АЖИЛАХ ХҮЧНИЙ ТОО /МЯН.ХҮН/



МАЛЫН ТОО /МЯНГАН ТОЛГОЙ/



ХОЙД БҮСИЙН ХҮН АМЫН ТОО



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР

ЧӨЛӨӨТ БҮС,
ТУСГАЙ БҮС ҮЙЛДВЭР
ТЕХНОЛОГИЙН
ПАРК

ГАЗАР ЗҮЙН
ЗААЛТ БҮХИЙ
ОРОН НУТГИЙН
БРЭНД

ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ,
АНГИЛАН ЯЛГАХ, ТОРДОХ,
ҮЙЛДВЭРЛЭХ

ТЭЭВЭР ЛОГИСТИК,
ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
КЛАСТЕР



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ХӨВСГӨЛ:

Мөрөн
Рэнчинлхүмбэ
Хатгал
Тариалан
Галт
Цагаан-Уул

БУЛГАН:

Хутаг-Өндөр
Хишиг-Өндөр
Дашинчилэн
Булган

ОРХОН:

Баян-Өндөр

Аялал жуулчлал

ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ТУЛГУУР АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал: Бүсийн байгаль газар зүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын эко системийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгож, Цэнхэр сувд байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулна.



Хойд бүсийн хамгийн том давуу тал байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд оршино. Монгол Улсын аялал жуулчлалын гол тулгуур төв бол Хөвсгөл аймаг. Гадаадын жуулчдын гол урсгал Монголын говь руу явдаг бол дотоодын жуулчдын хамгийн том аяллын маршрут Хөвсгөл нуур юм. 2024 оны статистик мэдээллээр нийтдээ 285,500 жуулчин ирсэн. Гадаадын 20 мянга гаруй жуулчин Хөвсгөл аймагт аялсан бол дотоодын 200 гаруй мянган иргэн Хөвсгөл аймгийг зорьжээ. ОХУ-аас 40,132 жуулчин иржээ.

Монгол Улсын хөгжлийн том нөөц салбар бол аялал жуулчлал. Байгаль экологи, үндэсний өвт зүйлүүд дээрээ тулгуурлан аялал

жуулчлалын бүс болж хөгжих боломж Хойд бүсэд байгаа учир аялал жуулчлалын дэд бүс болгохоор тодорхойлсон. Үзэсгэлэнт байгаль, нуур, гол мөрөн энэ бүс нутагт олон бий. Мөн Түрэг уйгурын түүх соёлын дурсгал газруудаас эхлээд сүүлийн үеийн сүм хийдүүд хүртэл байршдаг. Түүх соёлын өвүүдийг түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд гаргах боломжтой.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулаад орон нутагт бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлал, жижиг дунд, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь тогтвортой амьжиргааг дэмжих амьдралын чанарыг дээшлүүлэх том арга хэрэгсэл болно. Хойд бүсийн аялал жуулчлалын стратегийн хүрээнд бүс нутагт

тохирсон багц бүтээгдэхүүн гаргаад явах ажлыг одоо бүсийн аймгууд хэлэлцээд цааш явах ёстой.

Хөвсгөл аймаг руу явах жуулчдын урсгалыг Орхон, Булган аймгууд өөрийн нутгаар дайруулж, орлогоос авч үлдэх талд гол бодлогоо чиглүүлж хамтран ажиллах нь тус бодлогын гол зорилго юм. Хамтарсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгоход анхаарч ажиллах ёстой.

Хөвсгөл аймаг руу явах аялал жуулчлалын маршрут:

- Улаанбаатар хот-Орхон аймаг-Булган аймаг-Хөвсгөл аймаг
- Улаанбаатар хот-Лүн сум-Булган аймаг-Хөвсгөл аймаг



ХОЙД БҮСИЙН БИЗНЕСИЙН ИДЭВХЖИЛ



БҮСИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛЭЭР ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛНЭ

Бүсчилсэн хөгжлийн бодлого хувийн хэвшилд тулгуурлаж явна гэдгийг бодлого тодорхойлогчид хэлж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол зорилго хувийн хэвшлийг дэмжиж, хамтарч ажилласнаар илүү их хөрөнгө оруулалт татаж, улмаар улс орны, бүсийн, орон нутгийн хөгжлийг хурдасгана гэж үзэж байгаа юм.

Өнгөрсөн 30 жилийн улс орны хөгжилд төр түлхүү үүрэг гүйцэтгэж ирсэн бол ирэх 30 жилд хувийн хэвшлийн оролцоог түлхүү байлгана гэдэг зарчим шинэ хөгжлийн бодлогын гол түлхүүр гэдгийг тэд онцолж байна.

Бүсчлэн хөгжүүлэх бодлого бол тэр чигтээ бизнесийг, хувийн хэвшлийг дэмжсэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахад анхаарсан бодлогын баримт бичиг юм. Бүсийн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хамтран хэрэгжүүлэхээр тусгасан. Үүний тулд бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд төрийн бодлого бүсчилсэн байдлаар явах нь зөв гэдэг дээр санал нэгдэж буй юм.

Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан

үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг татвар, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, шинэ хоршоо хөдөлгөөнөөр хоршоологч, үйлдвэрлэгчдийг дэмжин жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны бизнес, инновацын төслүүдийг мөн дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулахыг зорьж буй. Төрөөс бизнесүүдийг идэвхжүүлэх, сэргээх, нэгдэх, хорших, дагнах боломж нөхцөлүүдийг бий болгоно. Өөрөөр хэлбэл, төр бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайтар бүрдүүлж, зөөлөн, хатуу дэд бүтцүүдийг холбосныг Бүсчилсэн хөгжлийн бодлогоор тодорхойлон олон хуульд нэмэлт өөрчлөлт хийхээр ажиллаж байна.

Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг бий болгохын тулд хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ. Чөлөөт бүс, тусгай бүс, үйлдвэр технологийн паркад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд төрөл бүрийн татварын хөнгөлөлт урамшуулал үзүүлнэ. Үйлдвэрлэл технологийн паркад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг нэгдсэн зохион байгуулалттайгаар экспортлох орчныг бүрдүүлнэ. Аж

ахуйн нэгжүүдийн борлуулалтын сувгуудыг олон улсын жишгээр дэмжиж хөгжүүлэхийг чухалчилж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр тулгуурласан шинэ татварын бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгт, Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, бүс бүрийн онцлогоор нь татварын ялгаатай бодлого хэрэгжүүлнэ. **Хоёрт**, салбар харгалзахгүйгээр боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, НӨАТ-ын зохицуулалт хийнэ. /Архи, тамхи гэх мэт салбарт хориглох заалт хэвээр/

Гуравт, нийгмийн салбарт хандив өргөсөн, хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжүүдийн жилийн борлуулалтын орлогын нэг хүртэлх хувийг татвараас чөлөөлнө.

Бүсчилсэн хөгжлийн бодлого бусад улс орон ялангуяа хоёр хөрш орны хөгжлийн бодлогуудтай уялдуулж хөгжүүлэх зорилт тавиад буй. Тиймээс боомтуудыг сэргээж, богино хугацаанд хөгжүүлж, гадаад худалдааны урсгалыг түргэн шуурхай явуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. Түүнчлэн улс орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээрийг үргэлжлүүлнэ. Өнөөдөр Монгол Улс Япон, Европ, БНСУ, Хятад, Энэтхэг орнуудтай Ази, Номхон далайн худалдааны түр хэлэлцээр хийсэн бол ОХУ, Хятад, Солонгос улсуудтай хэлэлцээрийн түвшинд явж байна.

Түүнчлэн Евроазийн эдийн засгийн коридор, Бүс ба зам гэсэн хөтөлбөр, төслүүдтэй өөрийн орны хөгжлөө уялдуулан ажилласнаар Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэж, зах зээлийг нээх замаар хувийн хэвшлийг дэмжсэнээр Монгол Улс хурдтай хөгжих гараа руугаа явна гэдэг нь шинэ хөгжлийн бодлогын амин сүнс гэж тодорхойлж байна.

ХОЙД БҮСИЙН БИЗНЕС

Хойд бүсийн бизнес хөрөнгө оруулалтын орчин бусад бүстэй харьцуулахад давуу талтай. Монгол Улсын эдийн засгийг нуруун дээрээ тээж ирсэн “Эрдэнэт” үйлдвэр бол маш том боломж. Одоо тус үйлдвэрийн дэргэд Зэс боловсруулах үйлдвэрийг барихаар төлөвлөж буй нь бүс нутгийн бизнес цэцэглэн хөгжих маш том үндэс суурь болно. Орон нутгийн бизнес эрхлэгчид өнөөдөр хоорондоо төрөлжиж, дагнаж, хамтарч нэгдэх хэрэгтэй. Ганц нэгээрээ жижиг эрх ашиг, жижиг орлогын төлөө бус том эрх ашиг, том орлогын төлөө явах цаг ирсэн. Сүү нь сүүгээрээ, арьс ширнийхэн арьс ширээрээ төрөлжиж дотроо кластер бий болгох замаар хурдтай хөгжлийг бий болгохыг

бодлого боловсруулагчид зөвлөж байна. Орхон аймгийн компани Булган, Хөвсгөлийн компаниудтай төрөлжилтөөрөө нэгдэж, хөрөнгө оруулалт татаж, бүс нутгийн кластерт орохыг л хэлээд байгаа юм.

Тухайлбал, Зэс боловсруулах үйлдвэрт ямар чиглэлээр яаж оролцож, хэрхэн ханган нийлүүлэлт хийх үү, ямар жижиг дунд үйлдвэрлэлийг хэнтэй, бүсийн ямар компаниудтай хамтран ажиллаж, ямар ашиг орлого олох уу гэдэг асуудалд одооноос анхаарч ажиллах хэрэгтэй юм. Хойд бүсийн мега Зэс боловсруулах үйлдвэр, Эгийн голын усан цахилгаан станц төслүүдийг дагаад олон жижиг, дунд үйлдвэрлэл бий болж, ажлын байр нэмэгдэж, айл өрхийн орлого өсөх том ирээдүй харагдаж байна. Энэ бүх боломжийг бүс нутагтаа шингээн авч, хөгжихөд хувийн хэвшлийнхэн одооноос амбицтай хөдөлж, бэлдэх нь чухал юм.

Үйлдвэрлэл технологийн болон дундын үйлдвэрлэлийн бүс нутгийн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгоод бүс дундын өртгийн сүлжээ, бүс хоорондын цаашлаад олон улсын өртгийн

сүлжээнд тоглогч болж оролцох боломж байна. Эдийн засаг нь эргэлтэд ороогүй нөөцүүдийг илрүүлж, анхан шатнаас нь эхлэн тордолт, үйлдвэрлэл технологи, инновац шингээсэн эцсийн бүтээгдэхүүн болгоод экспортбол бид ойрын хугацаанд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг 2-3 дахин, боловсруулах үйлдвэрлэлээ эцсийн бүтээгдэхүүн болговол 2 дахин өсгөх боломжтой. Түүнчлэн эцсийн борлуулалтаа бүс нутагт өөрсдөө зохион байгуулаад хийвэл орон нутаг дахь бүтээмж 3 дахин нэмэгдэнэ хэмээн манай эрдэмтэн судлаачид ярьж байна.

Хойд бүсийн нэг онцлог бол хүн ам олонтой. Хөвсгөл аймаг 136.000, Орхон аймаг 111.000, Булган аймаг 60.000 хүн амтай суурьшиж байна. Энэхүү давуу тал нь бизнесийн идэвхжил бий болж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Мөн бүсийн гурван аймагт боловсон хүчнийг бэлдэх их сургууль, коллеж байна. Дээр нь үйлдвэрлэлийн бүс Орхон аймаг, үйлдвэрлэгч сэтгэхүйд хэдийн 40 жил суралцсан ард иргэдийн энэхүү чиг хандлага маш том давуу тал болох юм.



Эрдэнэс үйлдвэр технологийн парк

Бодлогын байр суурь



У.Хүрэлсүх:

Монгол Улсын
Ерөнхийлөгч

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Эрүүл Монгол хүн”, “Илгээлт 2100” үндэсний хөдөлгөөн, хөтөлбөр “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-тай нягт уялдан хэрэгжсэнээр Монгол Улсын хөгжил дэвшил монгол хүн бүрд хүртээмжтэй, өгөөжтэй болох ёстой.



Н.Учрал:

УИХ-ын дарга

Төрд мэдэгдээд, зөвшөөрөл хүлээхгүйгээр шууд ажлаа эхлэх эрхийг хуульчлан нээнэ. АМНАТ-ыг аймаг, суманд нь түлхүү үлдээх, хөрөнгө оруулалт татах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах зэргээр орон нутгийн хөрөнгө санхүү, төсвийн бие даасан байдал, өргөн боломжийг нээж, бизнесийн орон зайг тэлж чөлөөлнө.



Г.Занданшатар:

Монгол Улсын
Ерөнхий сайд

Орон нутгийн хөгжлийн асуудлыг орон нутаг өөрөө шийддэг, төсвийн бие даасан байдлыг нь нэмэгдүүлсэн, мөнгөний эрх мэдлийг нь шилжүүлсэн жинхэнэ реформыг бид хийнэ. Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслүүдийн саналыг салбарын яамд, орон нутгаас авч, саналыг нэгтгэн, эрэмбэлж дараах 5 мега төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Т.Доржханд:

Монгол Улсын
Шадар сайд

Орон нутаг хөгжих боломж нь зах зээл үүсгэх буюу хүний төвлөрөл юм. Дараа нь зах зээлдээ чиглэсэн зам, эрчим хүч буюу дэд бүтэц бөгөөд эдгээрийг ажил хэрэг болгох суурь нь бүсчилсэн хөгжил юм.



Х.Ганхуяг:

Монгол Улсын
Шадар сайд

Хойд бүсийг байгаль хамгаалал, аж үйлдвэр, дэд бүтэц, аялал жуулчлалыг харилцан уялдуулсан, тогтвортой хөгжлийн жишиг бүс болгон хөгжүүлэх чиглэл баримталж байна. Байгалийн үнэт баялгийг хамгаалахтай зэрэгцэн нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэл, стратегийн ач холбогдол бүхий логистик төвүүдийг хөгжүүлэх, хил орчмын байршлын давуу талыг эдийн засгийн боломж болгон ашиглах чиглэлд бодлого, төлөвлөлт хийгдэж байгаа.



С.Бямбацогт:

Монгол Улсын сайд,
ЗГХЭГ-ын дарга

Засгийн газар төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээнд цахим хувьсгал хийх, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, эхний ээлжид иргэдэд газар өмчлүүлэх үйл явцыг хөнгөвчилж байгаа. Нутаг усандаа эзэн болсон малчдад амьдралын чанарыг нь сайжруулахад зориулж 1-5 га хүртэл газрыг өмчлөл эзэмшилд нь шилжүүлэх эрх зүйн эрс шинэтгэл хийхээр ажиллаж байна.



Ж.Энхбаяр:

Монгол Улсын Тэргүүн
Шадар сайд бөгөөд
Эдийн засаг,
хөгжлийн сайд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар эдийн засгийн өсөлтийн 60 хувийг хангаж байна. Энэ юутай холбогдож байна вэ гэвэл бүсчилсэн хөгжлийн бодлого үр дүнгээ өгч байгаагийн илэрхийлэл гэж харж болно. Бүс бүр бодлогын нэгдсэн зохион байгуулалттайгаар урт хугацааны бодлогыг авч хэрэгжүүлж чадвал амжилтад хүрч болно гэдгийг хэлэхийг хүсэж байна.



Б.Мэндсайхан:

Шадар сайдын
Бүсчилсэн хөгжлийн
асуудал хариуцсан
бодлогын зөвлөх

Бүсчилсэн хөгжлийн бодлогын цөм нь тусгай болон чөлөөт бүсүүдийг эдийн засгийн 'зүтгүүр' болгох явдал юм. Хойд бүсийн давуу талыг ашиглан экспортын шинэ гарцуудыг нээж эдийн засгийг төрөлжүүлэх нь бүсчилсэн хөгжлийн бодлогын чухал алхам юм.



Ж.Бат-Эрдэнэ:

УИХ-ын гишүүн

“Хөдөө аж ахуй” бол зөвхөн мал аж ахуй, үр тариа бус үндэстний тусгаар тогтнол, хүнсний аюулгүй байдал хийгээд бүс нутгийн хөгжлийн тулгуур юм. Төрийн бодлогоор дэмжсэн төсөл, хөтөлбөрүүд ард иргэдийн амьжиргаанд бодит “хөшүүрэг” болж байгаагийн нэг илрэл бол “Шинэ хөдөө” төсөл болон “Шинэ хоршоо” хөдөлгөөн юм. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд салбар бүрийн уялдааг хангаж, дэд бүтцийг хөгжүүлэх шаардлагатай.



Д.Үүрийнтуяа:

УИХ-ын гишүүн

Хойд бүс бол уул уурхай, аж үйлдвэрлэл, хөдөө ахуй тээвэр логистикийн чадавхыг хослуулсан хөгжлийн стратегийн зангилаа нутаг юм. Бүсийн хөгжил нь зөвхөн дэд бүтэц, барилга байгууламжаар хязгаарлагдахгүй, хүн төвтэй, тэгш боломж, ур чадварт суурилсан хөгжлийн шинэ загвар байх ёстой. Энэ агуулгаар Хойд бүсэд Монгол Улсын эдийн засгийн тулгуур багана болсон уул уурхай, аж үйлдвэрийн салбарыг хөдөө аж ахуйн салбартай хослуулан хөгжүүлэх бүрэн боломж байна.



Л.Мөнхбаатар:

УИХ-ын гишүүн

Хойд бүсийн хөгжилд төр, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагаа чухал. Бүсийн дэд бүтцийг нэмэгдүүлж, ажиллах хүчийг чадавхжуулах, эрчим хүчийг баталгаажуулж, бүс нутгийн бизнес эрхлэгчдэд татварын таатай орчин бий болгох ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатай. Ингэж чадвал Хойд бүс хөгжиж, иргэд уугуул нутагтаа ая тухтай, сэтгэл тэнүүн амьдрах боломж бүрдэнэ. Тус ажил эхнээсээ хэрэгжиж эхэлсэн гэдгийг хэлэх нь зүйтэй.



Б.Бат-Эрдэнэ:

УИХ-ын гишүүн

Хойд бүс бол аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутгийн том орон зай. Түүнчлэн газар тариалан, мал аж ахуй, хөнгөн аж үйлдвэр төвлөрөх боломжтой газар. Энэ чиглэлд анхаарч хөнгөн үйлдвэрийн цех байгуулж, бүсийн дэд бүтэц, цахилгаан станцын асуудлыг шийдэх шаардлагатай.



Д.Батлут:

УИХ-ын гишүүн

Бүсчилсэн хөгжлийн бодлогоор Хойд бүсийг аялал жуулчлал, аж үйлдвэрийн дэд бүс болгон хөгжүүлэхээр төлөвлөж зам холболт, зэс боловсруулах хайлуулах үйлдвэр, хавдрын төв эмнэлэг, олон улсын нисэх буудал, өндөр хүчин чадалтай усан цахилгаан станцыг байгуулах зэрэг дэд бүтцийн олон бүтээн байгуулалтыг хийнэ.



Л.Энх-Амгалан:

УИХ-ын гишүүн

Бүсчилсэн хөгжлийн нэг зорилт нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулан, утааг бууруулж, орон сууцжуулах юм. Ипотекийн зээлийг дан ганц орон сууцанд биш эрчим хүчний хэмнэлттэй, амины орон сууцанд ч олгодог болж, хашаандаа сайхан амьдрах зорилтыг хэрэгжүүлэн, орон нутагт өрхийн орлогод нийцсэн ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.



Ц.Даваасүрэн:

УИХ-ын гишүүн

“Үйлдвэрлэлгүй улс орон дугуйгүй машинтай адил юм”, “Тэнэгийн ухаан хойно”

Эрдэмтэн судлаачид



Д. Эрдэнэбаяр:

Бүсчилсэн хөгжлийн
Үндэсний хүрээлэнгийн
гүйцэтгэх захирал,
доктор, дэд профессор

Орон нутгийн өсөлтийн төвүүдийн эдийн засгийн төрөлжилт, чиг үүрэг, харилцан хамаарлыг тодорхойлох нь бүсчилсэн хөгжлийг бодлогын хэрэгжилтийн чухал алхам болно.



Г.Баттүвшин:

ШУТИС-ийн
Менеджментийн
сургуулийн захирал,
Доктор, Профессор

Хойд бүсийг аялал жуулчлал, шинжлэх ухаан, хөдөө аж ахуйн хосолсон хэлбэрээр хөгжүүлэхээр бодлого төлөвлөсөн. Хойд бүсийн хүний нөөцийн бодлого, эрдэм шинжилгээ, судалгааны чадамжийг нэмэгдүүлэх тал дээр нэлээн анхаарал хандуулж, судалгаа, сургалтын төвүүдийг бий болгохоор ажиллаж байгаа. Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбарыг хойд бүсэд хөгжүүлэх замаар нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд голчлон анхаарах хэрэгтэй.



Х.Цэвэлмаа:

МУИС-ийн Эдийн
засгийн хүрээлэнгийн
захирал, доктор /Ph.D/

Бүс нутгийн кластерыг хөгжүүлэхэд улс орнууд өөр өөрийн жишиг, туршлагатай. Мэдээж Монгол Улс өөрийн давтагдашгүй хөгжлийн замыг олох үе дээрээ ирээд байгаа болов уу гэж харж байна.



Р.Ринчинбазар:

МУИС-ийн профессор,
шинжлэх ухааны доктор
(SC-D профессор)

Нутаг дэвсгэрийн хөгжлийн ялгааг багасгах арга зам нь эдийн засгийн бүсүүдийг тогтоох юм. Нутаг дэвсгэрийн онцлогт нийцсэн хөгжлийг цогцлоож, улмаар улс үндэстнийхээ нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг амжилттай шийдэхэд бүсчилсэн хөгжил гол нөлөө үзүүлэх учиртай.



Б.Нарантуяа:

Удирдлагын академийн
тэнхимийн эрхлэгч,
доктор /Ph.D/,
дэд профессор

Ард иргэд нутаг дэвсгэрийн хаана амьдарч байгаа вэ гэдгээс үл хамаараад адилхан хөгжлийн боломж нөхцөлүүдийг хүртэх, эрхээ эдлэх, хэрэгцээ шаардлагатай үйлчилгээндээ амархан хүрэх нь чухал. Магадгүй бизнес эрхлэхэд зах зээл нь ойрхон, орлого олоод амьжиргаагаа дээшлүүлээд, амьдралын чанар нь илүү боломжийн түвшинд хүрэх нь хөгжлийн гол зорилго юм. Тиймээс бүсчилсэн хөгжил нь энэ бүхэнд хүрэхэд дөтөлж байгаа арга механизм гэж хэлмээр байна.



С.Дулам:

Ардын багш, хэл бичгийн
ухааны доктор /Ph.D/,
профессор

Монгол орны бүсчлэл болгон өөр өөрийн соёл түүхийн, байгаль, газар зүйн өвөрмөц онцлогтой байдаг. Нэн ялангуяа эртний бөө мөргөлийн уламжлал, Даян дээрхийн агуйнаас эхлээд цаатны мал маллагаа, аж ахуйг харуулсан өвөрмөц соёл аялал жуулчлалын томоохон бүтээгдэхүүн болж болох юм гэж харж байна.

Орон нутгийн удирдлагууд



Д.Пүрэв-Очир:

Булган аймгийн Засаг дарга, Хойд бүсийн зөвлөлийн дарга

Хойд бүс ухаалаг хөдөө аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэрийн алтан гурвалжинг барин хамтдаа хөгжинө. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд шилжиж амьдрах хамгийн боломжтой аймагтар Булган гэж нэрлэсэн байсан. Энэ үнэн. Байгалийн үзэсгэлэнт газруудтай, дэд бүтэц, зам харгуй холбогдсон. Аймгийн төв маань хэт төвлөрсөн биш, тэлэх газартай. Зөв төлөвлөлт зөв бодлогоор иргэдээ нэг зүг рүү чиглүүлэн ажиллаж чадвал Булган аймаг богино хугацаанд хөгжих боломжтой гэж харж байгаа. Бидний ойрын хугацаанд зорьж буй ажил бол Хойд бүсийн хэмжээний үйлдвэрлэл технологийн паркийг Булган аймагтаа барьж байгуулах явдал юм.



Ж.Ганболд:

Булган аймгийн ИТХ-ын дарга

Бид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг орон нутгийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, хөгжлийн хөтөлбөрт тусгах, бүсийн төсөл хөтөлбөрүүдэд санал өгөх, хяналт тавих чиглэлээр идэвхтэй оролцож ажиллахаар төлөвлөж байна. Манай аймгийн хувьд хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгалийн баялаг зэрэг давуу тал олон бий. Энэ бүхнийг бүсчилсэн хөгжлийн хүрээнд оновчтой ашиглах, хөгжлийн шинэ хөшүүрэг болгох бодит боломж харагдаж байна. Тиймээс Булган аймаг бүсийн хөгжилд манлайлж оролцоно. Манай аймгийн хувьд тогтвортой, ил тод, иргэдийн оролцоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг чухалчилж байна.



Б.Зоригтбаяр:

Орхон аймгийн Засаг дарга

Орхон аймгийн хувьд байгалийн аялал жуулчлал хөгжүүлэхэд дамжиж өнгөрөх транзит хот, үйлдвэрлэлийн бүс байхаар төлөвлөсөн. Жилийн дөрвөн улиралд тогтвортой ажиллах усан паркийн төслийн зургийг гаргаж байна. Ирэх жил бүтээн байгуулалт эхэлнэ. Эрдэнэт Арена-г барина. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэсэн аж үйлдвэрийн паркууд барина. Бид ирээдүйн хөгжлийн шинэ үзэл баримтлалаараа гурван том хөтөлбөр, үүнийг дагасан 60 дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрүүдээ 2024-2028 болон 2028-2032 гэсэн он шатлалаар хэрэгжүүлэхээр тусгасан.



Д.Мөнхбат:

Орхон аймгийн ИТХ-ын дарга

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын гол “малгай” хууль нь 2003 онд буюу одоогоос 22 жилийн өмнө батлагдсан бөгөөд нийтдээ 12 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Энэ хуульд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх үүрэг тодорхой тусгагдаагүй, зохицуулаагүй зүйлүүд их бий. Тэгэхээр хамгийн эхэнд Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй тус тус уялдуулан шинэчлэх нь зүйтэй.

Д.Пүрэвдорж: Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга



Хойд бүсийн аймаг бүрд тулгамдсан асуудлууд бий. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсүүдийн онцлогоор хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Бодит байдалд төр засгаас шийдэх асуудлууд их байна. Тухайлбал, “Цахим аймаг” бодлогын

хүрээнд бүсийн аймгуудын цахимжилтад анхаарах, хамтын төлөвлөлт, үр дүнг хянах, дүгнэх зэргээр бүсчлэн хөгжих аргагүй, тогтолцоог нэвтрүүлэх шаардлага байна. Хөвсгөл аймгийн хувьд аялал жуулчлалын салбарт жилээс жилд ахиц гаргахын төлөө ажиллаж байна.



АЙМАГ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХ НЬ



Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-ны даалгавраар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн хэрэгжүүлж буй “Эдийн засгийн олон талт

өсөлтийг дэмжих” (ICED) төсөл Орон нутгийн хөгжлийн индекс (ОНХИ) цахим платформын шинэчилсэн хувилбарыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр албан ёсоор хүлээлгэн өглөө.

ОНХИ цахим платформ нь бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг бодит тоо баримт дээр суурилан боловсруулах мөн институтийн болон техникийн чадавхыг бэхжүүлэхэд чухал юм.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС АЧ ХОЛБОГДОЛ

АЙМАГ, СУМЫН
ХӨГЖЛИЙН
ӨНӨӨГИЙН
ТҮВШИНГ
ТОДОРХОЙЛЖ,
ЭРЭМБЭЛЭХ;

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫГ
ОНОВЧТОЙ
ТӨЛӨВЛӨХ,
ҮР АШГИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ;

ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
САНГИЙН
ХӨРӨНГИЙГ
ОНОВЧТОЙ
ХУВААРИЛАХ;

ОРОН НУТАГТ
ЧИГЛЭСЭН
ШИНЖЛЭХ УХААНД
СУУРИЛСАН
ХӨГЖЛИЙН
БОДЛОГО
БОЛОВСРУУЛАХАД
СУУРЬ СУДАЛГАА
БОЛГОЖ АШИГЛАХ;

АЛИВАА ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРИЙН
ҮР НӨЛӨӨГ
ХЭМЖИХЭД,
АШИГЛАХ;



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ АЙМАГ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДИТ ТҮВШИНД ТУЛГУУРЛАН ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨНӨ.

21

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

330

СУМЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

33

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

“ТӨСВИЙН ТУХАЙ” ХУУЛЬ

59 дүгээр зүйл. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
59.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

59.3.1. орон нутгийн хөгжлийн индекс;
59.3.2. хүн амын тоо;
59.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээ;
59.3.5. өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

“АРГАЧЛАЛ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”

Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоол



БОЛОВСРОЛ



ЭРҮҮЛ МЭНД



ЭДИЙН ЗАСАГ



ДЭД БҮТЭЦ




БАЙГАЛЬ ОРЧИН



НИЙГМИЙН БУСАД


ЕРӨНХИЙ ИНДЕКС




Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “АРГАЧЛАЛ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” 20 дугаар тогтоолоор ОНХИ-г тооцох аргачлалыг баталсан. Тус аргачлалын дагуу 330 сумын 33 шалгуур үзүүлэлтээр сум, аймгийн хөгжлийн индексийг тодорхойлдог.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС


Хөвсгөл аймгийн ерөнхий индекс **0.470**



Булган аймгийн ерөнхий индекс **0.493**



Орхон аймгийн ерөнхий индекс **0.496**



Хойд бүсийн ерөнхий индекс **0.496**



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС БА ХОЙД БҮС:

ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗУРАГЛАЛ

Хойд бүс нь газарзүйн хувьд төвийн аймгуудтай ойр оршдог, хүн амын нягтаршил дунд, мал аж ахуй, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ хосолсон эдийн засгийн бүтэцтэй тул эдийн засгийг төрөлжүүлэх нь хөгжлийн үндсэн түлхэц болно. Үүнд жижиг, дунд үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал, экотуризмыг хөгжүүлэхийг онцлох хэрэгтэй.

Хойд бүсийн хөгжлийн ерөнхий индекс 0.496 нь дундаж, харьцангуй тогтвортой байгааг харуулж байна. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ харьцангуй сайн, дэд бүтцийн хүртээмж, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд дундаас доогуур түвшинд байна.

БҮСИЙН ХӨГЖЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Хойд бүсийн хөгжлийг дэмжихэд эдийн засгийг төрөлжүүлэх, дэд

бүтцийн хүртээмжийг сайжруулах, нийгмийн салбарын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнд орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр бизнес эрхлэлтийг дэмжих, хөрөнгө оруулалтыг татах бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй. Байгаль орчны хувьд бүсийн онцлог давуу талыг хадгалж, тогтвортой ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг ашиглах нь хөгжлийн чухал чиглэл болно.

ХОЙД БҮСИЙН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН СҮЛЖЭЭ



ТӨЛӨВЛӨЖ БҮЙ ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН СҮЛЖЭЭ

АВТО ЗАМ

Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн авто зам;

Бага-Илэнх боомт-Хутаг-Өндөр сум чиглэлийн авто зам;

ТӨМӨР ЗАМ

Улаанбаатар хот-Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр зам

ТЭЭВЭР ЛОГИСТИК

- 1 Бүсийн тээвэр логистикийн төв, хуурай боомт
- 11 Орон нутгийн тээвэр логистикийн төв

Д.ЭРДЭНЭБАЯР: Хойд бүс бол Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг тэтгэх стратегийн бүс

Монгол Улс бүсчилсэн хөгжлийн бодлогыг бодитоор хэрэгжүүлж эхэлснээр улс орны хөгжлийг зөвхөн нийслэлд төвлөрүүлэх бус, бүс нутаг бүрийн онцлог, давуу талд тулгуурлан тэнцвэртэй хөгжүүлэх шинэ шатанд шилжиж байна. Үүний нэг тод жишээ нь хойд бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлт юм. Байгалийн баялаг, уламжлалт аж үйлдвэр, тээвэр логистикийн стратегийн байршил бүхий хойд бүсийг улсын эдийн засгийн тулгуур бүс болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал, доктор, дэд профессор Д.Эрдэнэбаяртай ярилцлаа.



-Хойд бүсийн хөгжлийг төлөвлөхдөө ямар үндсэн зарчмыг баримталж байна вэ?

-Бүсчилсэн хөгжлийн бодлогын гол философи бол бүс бүр өөрийн онцлог, давуу талд тулгуурлан хөгжихийн зэрэгцээ бусад бүсгүйгээ харилцан уялдаатай, тэнцвэртэй өсөх явдал юм. Хэрэв бүсүүд харилцан нөхөх, дэмжих байдлаар хөгжиж чадвал улс орны эдийн засаг илүү тогтвортой, эмзэг бус болно. Хойд бүсийн хувьд уул уурхай, ой, усны нөөц, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн

суурь аль хэдийн бүрдсэн. Үүн дээр ОХУ-тай хиллэдэг, төмөр зам, авто замын олон улсын коридорууд огтлолцдог байршил нь тээвэр, логистикийн томоохон давуу талыг бий болгож байна. Иймээс бид энэ бүсийг хөгжүүлэхдээ таамаг, хүсэлд бус, бодит судалгаа, нарийвчилсан тооцоонд тулгуурласан.

-Хэрэгжилтийн эхний жилд ямар ажлуудыг түлхүү хийв?

-Эхний жилд хамгийн чухал ажил бол бодлого боловсруулах суурь болох бодит өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх явдал

байсан. Энэ хүрээнд хойд бүсийн бүх аймаг, сумдыг хамарсан олон талт судалгааг зохион байгуулсан. Судалгаагаар хүн амын байршил, шилжилт хөдөлгөөн, эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн зах зээл, дэд бүтцийн хүртээмж, тээвэр логистикийн холболт, байгалийн баялгийн ашиглалтын боломж зэрэг үзүүлэлтүүдийг нэгтгэн шинжилсэн. Үүний зэрэгцээ орон нутгийн удирдлага, бизнес эрхлэгчид, иргэдтэй уулзаж, бодит нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг газар дээр нь

тодорхойлсон. Энэ нь хөгжлийн төлөвлөгөөг цаасан дээр үлдэх бус, хэрэгжих боломжтой, орон нутгийн бодит хэрэгцээнд нийцсэн болгох чухал суурь болсон.

-Урт хугацааны төлөвлөгөөнд аймаг, сумдын үүргийг хэрхэн ялгаж байна вэ?

-Бид бүх аймаг, сумыг ижил түвшинд хөгжүүлэх зорилт тавиагүй. Харин аль суурин хөгжлийн төв болж чадах, аль нь түүнийг дагасан дэд бүсийн үүрэг гүйцэтгэх боломжтойг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлсон. Монгол орны уудам газар нутаг, хүн амын тархалтын онцлогийг харгалзан хөгжлийг тодорхой цэгүүдэд төвлөрүүлж, түүний үр өгөөжийг эргэн тойрны нутагт түгээх нь илүү үр ашигтай. Иймээс улс даяар 91 суурин газрыг хөгжлийн төв болгон тодорхойлж, эдийн засаг, нийгмийн үйлчилгээ, аж үйлдвэрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх бодлого баримталж байна.

-Хойд бүсэд хэдэн хөгжлийн төв байгуулахаар төлөвлөж байгаа вэ?

-Хойд бүсэд 11 орон нутгийн хөгжлийн төв байгуулахаар төлөвлөж байна. Одоогоор Булган аймгин орон нутгийн хөгжлийн төвд байгалийн нөхцөл нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл,

үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборын техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж дууссан байна.

Аймгийн төвүүдээс гадна стратегийн байршилтай, үйлдвэрлэл, логистик, аялал жуулчлалын чадамжтай сумдын төвүүдийг хамруулна. Сонголтыг хийхдээ хүн амын төвлөрөл, тээврийн сүлжээ, түүхий эдийн нөөц, зах зээлийн ойр байршлыг харгалзсан. Хөвсгөл, Булган аймгийн хувьд хөрөнгө оруулалтын үндсэн чиглэл нь Ухаалаг хөдөө аж ахуй, Аялал жуулчлал, Хөдөө аж ахуйн нөөцөд түшиглэсэн хөнгөн үйлдвэрийг илүү түлхүү чиглүүлэх боломжтой юм.

Дээрх нөхцөл байдалын дүн шинжилгээ, үнэлгээнээс харахад хөрөнгө оруулалт, нөөцийн хувьд боломжит гол үзүүлэлтүүд нь Аялал жуулчлал, Ухаалаг хөдөө аж ахуй, ХАА-н нөөцөд түшиглэсэн хөнгөн үйлдвэр, Уул уурхайд тулгуурласан хүнд аж үйлдвэр, Аялал жуулчлалын хөгжил нь Хойд бүсийн тэргүүлэх чиглэл болох боломжтой байна.

Эдгээр тэргүүлэх чиглэлийг хөгжүүлснээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, нөөцийг оновчтой хуваарилах замаар хүн амын амьжиргааг нэмэгдүүлэх, дундаж наслалтыг уртасгах, гэмт хэргийн гаралтыг бууруулах замаар сул

”

Бид ямар онол арга зүйг үр дүнтэй ашиглаж болох вэ гэсэн асуултыг эрэлхийлэн байнга судалгаа, шинжилгээ явуулж ирсэн. Өнөө цагт дэлхий нийтээр шинжлэх ухаан, технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжиж, даяаршиж буй нийгэмд шилжиж байна. Энэ үеийн бас нэг онцлог нь улс орны хөгжил тодорхой “хөгжлийн төвүүд”-рүү “шилжиж” байгаа явдал юм. Иймээс орон зайн буюу бүс нутгийн шинжлэх ухааны судалгаанд тулгуурлан өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн шинэ загварыг тодорхойлох шаардлага бий болсон гэж хэлж болно. ”

тал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой. Мөн орон нутгийн байгалийн нөхцөл, нөөц, бололцоо, хөрөнгө оруулалт гэсэн үзүүлэлтүүд нь харилцан бие биетэйгээ нөхцөлдөн бүс нутгийн хөгжлийг хангахад чухал үүрэг, оролцоотой юм.



ХОЙД БҮСИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИ



БҮС НУТГИЙН ИНТЕГРАЦИ

ЕНИСЕЙ СИБИРИЙН БҮС НУТАГ - ХАНГАЙН НУРУУНЫ АЙМГУУД

Улс: Монгол, Орос,

Аймаг, муж: Хөвсгөл, Булган, Орхон, Красноярский хязгаар, Эрхүү муж

Боомт: Ханх - Монды, Бага-Илэнх-Мугур Аксы

ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОРУУД

1. КРАСНОЯРСК-Тайшет-Эрхүү-Бага-Илэнх-Булган-Хархорин
2. КРАСНОЯРСК-Тайшет-Эрхүү-Ханх-Хатгал-Мөрөн

ГОЛ ЧИГЛЭЛҮҮД


- ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО
- АЧАА ЭРГЭЛТ - ЗОРЧИГЧ УРСГАЛ
- ЭРЭЛТ - НИЙЛҮҮЛЭЛТ
- ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН НЭГДСЭН СИСТЕМ

АЖ ҮЙЛДВЭР ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ

- БҮС НУТГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ
- ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ
- БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ

ӨНГӨТ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИРЭЭДҮЙН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛНО

ТЭЗҮ-ИЙГ БНХАУ-
ЫН CHINA ENFI
ENGINEERING CO.
LTD ТӨРИЙН ӨМЧИТ
КОМПАНИТАЙ
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ
ХИЙЛГЭЖЭЭ



Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, эрчим хүчний хараат байдлыг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг чухал ач холбогдолтой 14 мега төслийг Засгийн газар 2024-2028 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр төслийн нэг, хойд бүсийн хөгжлийн тулгуур болох “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийг 2027-2028 онд ашиглалтад оруулахаар тооцож, бэлтгэл ажил аль хэдийн эхлээд буй.

Өнөөдрийн байдлаар Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр (ЗББУ)-ийг барьж байгуулахаар холбогдох Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, Техник, технологийн түвшний үнэлгээ болон геоэкологи, гидрогеологийн суурь

судалгааны ажлуудыг гүйцэтгэн баталгаажуулсан байна. Мөн ЗББУ-ийг барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах техникийн даалгаврыг боловсруулсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 60 дугаар захирамжаар олон улсын нээлттэй тендер зохион байгуулах бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Зэсийн баяжмалыг хайлуулах, боловсруулах технологийн процессыг Эрдэнэт үйлдвэр сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд судалж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй 120 гаруй үйлдвэрт ашиглаж буй технологиудыг харьцуулан үзээд, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардал, металл авалт, найдварт ажиллагаа, аюулгүй байдал, байгаль орчинд үзүүлэх

Эрдэнэт үйлдвэр 2025 онд, **60 мянган тонн** зэсийн баяжмал биржээр арилжаалахаар төлөвлөж, өнөөдрийн байдлаар, 5 удаагийн арилжааг амжилттай хийж, **25 мянган** тонныг борлуулаад байна.

Оны эхний хагас жилд хүдэр олборлолт, боловсруулалтын төлөвлөгөө давж, орлогын төлөвлөгөөг **109 хувиар** биелүүлжээ.

Эрдэнэт үйлдвэр, өнгөрсөн онд **273 тэрбум** төгрөгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлжээ.

сөрөг нөлөөлөл болон хамгийн гол нь “Эрдэнэтийн овоо” ордын хүдрийн шинж чанар, эрдсийн найрлага, үйлдвэрлэлийн үндсэн технологитой таарч буй байдал зэрэг голлох үзүүлэлтүүдийг харгалзан БНХАУ-ын “шинэ технологийг” эцсийн байдлаар сонгожээ. Тухайн үед Монгол-Оросын хамтарсан үйлдвэрийн Зөвлөл болон Эрдэнэт үйлдвэрийн Техникийн зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж, холбогдох ТЭЗҮ-ийг хийлгүүлэн, салбарын мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулсан байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь сүүлийн үеийн зэсийн баяжмал хайлуулах технологиудыг харьцуулан судалсны үндсэн дээр зэсийн баяжмалыг урьдчилан нэмэлт боловсруулалтад оруулах шаардлагагүй, бага агуулгатай баяжмал боловсруулах боломжтой, хөрөнгө оруулалт болон ашиглалтын зардал бага, бүрэн автоматажсан SKS технологийг сонгон, уг технологиор Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2019 онд БНХАУ-ын China ENFI Engineering Co., Ltd төрийн өмчит компанитай гэрээ байгуулан хийлгэсэн байна. ENFI компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны зургаадугаар сарын 22-ны өдрийн өргөтгөсөн хурлаар, элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр тодотгосон ТЭЗҮ-ийг 2025 оны наймдугаар сарын 12-ны өдрийн хурлаар тус тус дэмжжээ.

Үйлдвэрлэл, технологийн паркийн үндсэн цөм үйлдвэр нь Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байх юм. Төслийн нийт хөрөнгө оруулалт 772.9 сая ам.доллар бөгөөд хөрөнгө оруулалтаа 8.8 жилд нөхөх тооцоотой. Үйлдвэр жилд 124 мянган тонн катодын зэс үйлдвэрлэхээр төлөвлөөд байгаа юм.

Эрдэнэт үйлдвэр бол зөвхөн уул уурхайн анхдагч, жишиг үйлдвэр төдийгүй үе үеийн чадварлаг

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮНДСЭН ЦӨМ ҮЙЛДВЭР НЬ ЗЭСИЙН БАЯЖМАЛ ХАЙЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

инженер, уурхайчдын өлгий, мэргэжилтэн бэлтгэсэн оюуны их уурхай юм. Тиймээс энэхүү бааз суурийг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах нь стратегийн чухал шийдвэр гэдгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгжийн дарга Б.Алтангэрэл онцлов.

Боловсруулах үйлдвэрүүдийг Үйлдвэрлэл, технологийн парк хэлбэрээр байгуулах нь Монгол Улсыг аж үйлдвэржсэн орон болгох, эдийн засгийг төрөлжүүлэх, тэлэх, өнгөт металлургийн үйлдвэрлэл болон дагалдах үйлдвэрүүдийг хөгжүүлэх, технологийг

нутагшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх гэх мэт олон талын ач холбогдолтой.

Өнөөгийн түвшинд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц (ажлын гүйцэтгэл: авто зам 60%, төмөр зам 98%, ус хангамж, ариутгах татуургын систем 100%, цахилгаан хангамж 13%)-ийг инженерийн нарийвчилсан зураг төслийн дагуу барьж байгуулах ажлууд хийгдэж байгаа бөгөөд түүнд шаардлагатай санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ бүрэн хариуцан ажиллаж байгаа юм.

ҮТП-ийн хүрээнд Зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэрээс гадна Молибдены баяжмал боловсруулах, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр, Эрдэнэт-машин цогцолбор, Кабель утасны үйлдвэрүүдийг байгуулахаар төлөвлөн төслүүдийн ТЭЗҮ-ийг батлуулжээ. Үүгээр зогсохгүй дээрх үйлдвэрүүдийн түүхий эдийг бэлтгэх, бүтээгдэхүүнийг боловсруулах зэс нунтаг, зэс трубаны зэрэг дагалдах үйлдвэрүүдийг барихаар төлөвлөж байна.

ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Зорилго: Жилд 560 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 125 мянган тонн катодын зэс, 72 кг алт, 38.2 тонн мөнгөн гулдмай болон 182 мянган тонн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ.

Санхүүжилт: Төрийн өмчит ААН-ийн хөрөнгө оруулалт, Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад эх үүсвэр.


Хүрэх үр дүн: Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр үзүүлнэ. Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Ач холбогдол: Тухайн цогцолборт хэрэгжих боломжтой шинэ шинэ төслүүдийн ашигт ажиллагаанаас шалтгаалж, тасралтгүй өсөн нэмэгдэх бүрэн боломжтой дээр ажлын байр нэмэгдүүлэх, гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчдыг татах, урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн бодит хэрэгжилтийг хангах суурь нөхцөлийг бий болгоно.

ХОЙД БҮС

Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын экосистем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс болно.



 ХӨВСГӨЛ АЙМАГ
ХӨВСГӨЛ ДАЛАЙ

БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ 37

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ





ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

„ БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС „

СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Цэнхэр сувд” байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулна.

ЭРЧИМ ХҮЧ

Булган аймгийн Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.

Мөрөн хотод бүсийн дата төв байгуулна



Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Хөвсгөл, Булган аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

ХОЙД БҮС

НИЙТ 22 ТӨСӨЛ

Тээвэр
логистикийн

5

Хот байгуулалт, боомт,
бүтээн байгуулалтын

5

Соёл, аялал
жуулчлалын

4

Боловсрол,
эрүүл мэндийн

5

Эрчим
хүчний

1

Үйлдвэр
үйлчилгээний

2



Орхон аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор”-ыг байгуулна.

ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ, ХИЛИЙН БООМТ


Эрдэнэт хотод бүсийн тээвэр, логистикийн төв байгуулна.

Ханх, Бага-Илэнх боомтуудыг өргөжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

ХҮНД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Орхон аймагт зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.

“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО” ХОЙД БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ОЛДВОР


РУНИ БИЧЭЭСТЭЙ АЛТАН ЗООС
1983 онд Булган аймаг
Бүрэгхангай сум



БУРХНЫ ДҮРСТ АЛТАН ЧИМЭГ
Хөвсгөл аймаг
Улаан-Уул сум



ХҮРЭЛ ТОЛЬ
2016 онд Орхон аймаг
Жаргалант сум



ХҮРЭЛ ДУУЛГА
1992 онд Булган аймаг
Хутаг-Өндөр сум



ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ҮНЭТ ӨВ



СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮС, ГЕОПАРК

3.3.1. Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, **Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг** төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна

ТАРВАГАТАЙН БЭЛЧИР, БУЛГАН



ХӨВСГӨЛ НУУР, УРАН ДӨШ ХАЙРХАН



УРАН ТОГОО, БУЛГАН



Зургийг Б.Эрдэнэбулган

БУЛГАН АЙМАГ

16 СУМ, **1** ТОСГОНТОЙ

60 ГАРУЙ МЯНГАН ХҮН
АМТАЙ

УЛААНБААТАР ХОТООС
430 КМ АЛСЛАГДСАН

ОРОН НУТГИЙН
ЧАНАРТАЙ **ОНГОЦНЫ**
БУУДАЛТАЙ

3.0 СЯА ТОЛГОЙ

СУМУУД **2-4 МЯНГАН**
ИРГЭНТЭЙ

АЙМГИЙН ТӨВДӨӨ **12.5**
МЯНГАН ХҮН АМТАЙ

19 МЯНГАН ӨРХТЭЙ

ҮҮНИЙ **9.4 МЯНГА** НЬ
МАЛЧИН ӨРХ

ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ
732 ӨРХ

51 ХУВЬ НЬ ХӨДӨӨ АЖ
АХУЙГААС БҮРДЭНЭ.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР
35 ХУВИЙГ ЭЗЭЛНЭ.

17 МЯНГАН ХҮҮХЭДТЭЙ

Эх сурвалж: ҮСХ, Булган аймгийн
статистикийн хэлтэс





Зургийг Б.Эрдэнэбулган

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

БУЛГАН АЙМАГ

ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ

Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ /Булган, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Дашинчилэн/.

БАЙГАЛЬ ОРЧИН

Сэлэнгэ мөрний сав газрын усны урсац бүрэлдэх эх, нэн ховор, ховор амьтан ургамал бүхий 1.5 сая га газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авна.

ЭРЧИМ ХҮЧ

Булган аймгийн Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.

БОЛОВСРОЛ

Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, Булган аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.

ТЭЭВЭР ЛОГИСТИК, БООМТ

Бага-Илэнх боомт-Хутаг-Өндөр сум чиглэлийн авто зам барина.

Бага-Илэнх боомтуудыг өргөжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Улаанбаатар хот- Шинэ Хархорум хот чиглэлийн авто замын бүсэд ногдох хэсгийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ.

Улаанбаатар хот- Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр замын бүсэд ногдох хэсгийг барина.

НИЙТ 8 ТӨСӨЛ

Үйлдвэр
үйлчилгээний

1

Хоёрдугаар үе шат
2025-2040 он

Эрчим хүчний

1

Нэгдүгээр үе шат
2025-2028 он

Байгаль орчны

1

Гуравдугаар үе шат
2025-2050 он

Боловсрол


1

Нэгдүгээр үе шат
2025-2028 он

Тээвэр логистик,
боомтын

4

Хоёрдугаар үе шат
2024-2040 он



ОРХОН АЙМАГ



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫГ ТҮШИГЛЭН БАЙГУУЛСАН ЭРДЭНЭТ ХОТ ӨРГӨЖИН ТЭЛЖ ХХ ЗУУНЫ МАНЛАЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТҮҮХЭН ГЭРЧ БОЛОН СҮНДЭРЛЭЛЭЭ.

1974 ОНД БУЛГАН АЙМГИЙН **“ЭРДЭНЭТ ХОРОО”**

1976 ОНД ЭРДЭНЭТ ХОТ НЭРТЭЙГЭЭР БАЙГУУЛАГДАЖ БАЙСАН
МОНГОЛЫН ГУРАВ ДАХЬ ШИНЭ ХОТ

1994 ОНД НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН
ӨӨРЧЛӨЛТӨӨР **ОРХОН АЙМАГ** БОЛСОН ЮМ.



106.4 МЯНГАН СУУРИН
ХҮН АМТАЙ

29 БАГИЙН **30.3**
МЯНГАН ӨРХТЭЙ

ХҮН АМЫН ЖИЛИЙН
ӨСӨЛТ **1.1** ХУВЬТАЙ

НИЙТ ХҮН АМЫН
57.6 ХУВИЙГ ХҮҮХЭД
ЗАЛУУЧУУД ЭЗЭЛЖ
БАЙНА

**ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ,
УУР АМЬСГАЛ:**

ОРХОН АЙМАГ НЬ
УЛААНБААТАР ХОТООС **371**
КМ-ИЙН ЗАЙД БАЙРЛАДАГ
БУЛГАН, СЭЛЭНГЭ АЙМАГТАЙ
ХИЛЛЭДЭГ

ДАЛАЙН ТҮВШНЭЭС
ДЭЭШ **1200** МЕТРТ
ӨРГӨГДСӨН

84.4 МЯНГАН ГА ГАЗАРТАЙ

ГАЗАР НУТАГ:

54.9 ХУВИЙГ ХӨДӨӨ АЖ АХУЙН
ЭДЭЛБЭР ГАЗАР

24.5 ХУВИЙГ ХОТ СУУРИН ГАЗАР

18.8 ХУВИЙГ ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

1.4 ХУВИЙГ ЗАМ, ШУГАМ, СҮЛЖЭЭ

0.3 ХУВИЙГ УСАН САН БҮХИЙ ГАЗАР

0.1 ХУВИЙГ УЛСЫН ТУСГАЙ
ХЭРЭГЦЭЭТ ГАЗАР ЭЗЭЛДЭГ

Эх сурвалж: ҮСХ, Орхон аймгийн статистикийн хэлтэс

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

ОРХОН АЙМАГТ

ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ

Орхон аймагт зэс боловсруулах, металлурги-химийн үйлдвэр болон бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл технологийн парк байгуулна.

Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.
/Баян-Өндөр/

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

БОЛОВСРОЛ

Орхон аймагт бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан "Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор"-ыг байгуулна.

ТЭЭВЭР ЛОГИСТИК, БООМТ

Эрдэнэт хотод бүсийн тээвэр логистикийн төв байгуулна.

ЭРҮҮЛ МЭНД

Орхон аймагт бүсийн эм хангамж, эмнэлэгийн хэрэгслийн нөөцийн агуулах байгуулна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, осол гэмтлийн болон мэс заслын тусламж, үйлчилгээгээр төрөлжүүлнэ.

НИЙТ 7 ТӨСӨЛ

Үйлдвэр
үйлчилгээний

2

Нэгдүгээр үе шат
2024-2028 он

Хөдөө аж
ахуй

1

Гуравдугаар үе шат
2024-2050 он

Боловсрол

1

Нэгдүгээр үе шат
2024-2030 он

Тээвэр логистик,
боомтын

1

Хоёрдугаар үе шат
2030-2035 он

Эрүүл мэндийн


2

Нэгдүгээр үе шат
2025-2030 он

Баян-Өндөр



Жаргалант


 Хөдөө аж ахуй

 Үйлдвэр

 Боловсрол

 Үйлчилгээ

 Эрүүл мэнд

 Бүсийн оношлогооны төв

ХӨВСГӨЛ АЙМАГ

ХӨВСГӨЛ АЙМАГ НЬ **1931**
ОНД БАЙГУУЛАГДСАН

УЛААНБААТАР ХОТООС **750**
КМ ЗАЙД ОРШДОГ

ХОЙД ТАЛААРАА ОХУ,
БАНУУН, ЗҮҮН БОЛОН
ӨМНӨ ТАЛААРАА ЗАВХАН,
БУЛГАН, АРХАНГАЙ
АЙМАГТАЙ ХИЛЛЭДЭГ

107.2 МЯНГАН КМ.КВ
ГАЗАР НУТАГТАЙ

ГАЗАР НУТГИЙН
ХЭМЖЭЭГЭЭРЭЭ МОНГОЛ
УЛСДАА **6** ДУГААРТ ОРДОГ

ДАЛАЙН ТҮВШНЭЭС **1500-**
3000 МЕТРТ ОРШДОГ

40352 ӨРХ, **136,436** ХҮН
АМТАЙ

ХАЛХ, ДАРХАД, ХОТГОЙД,
УРИАНХАЙ, БУРИАД,
ЦААТАН ГЭСЭН ЗУРГААН
ЯСТАН АМЬДАРДАГ ОЛОН
ЯСТНЫ ӨЛГИЙ НУТАГ

ЖИЛД **125000** ОРЧИМ
ГАДААД ДОТООДЫН
ЖУУЛЧИН ХӨВСГӨЛ
АЙМАГТ АЯЛДАГ

МОНГОЛ УЛСАД ИРЖ БҮЙ
ЖУУЛЧДЫН **20** ОРЧИМ
ХУВЬ НЬ ХӨВСГӨЛ АЙМАГТ
АЯЛДАГ

Эх сурвалж: ҮСХ, Хөвсгөл аймгийн
статистикийн хэлтэс





БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

” БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ТӨРӨЛЖСӨН, АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС ”

ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮД

ХӨВСГӨЛ АЙМАГТ

ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ

Орон нутгийн хөгжлийн төвүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ. /Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Хатгал, Тариалан, Галт/

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Бүсийн байгаль, газарзүйн онцлогийг харгалзан хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурын экосистемийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд “Цэнхэр сувд” байгалийн шинжлэх ухааны музейн цогцолбор байгуулна.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ

Мөрөн хотод бүсийн дата төв байгуулна.

Хөвсгөл аймагт цаг уурын доплерын радарын станц байгуулна.

Мөрөн хотод байрлах радио, өргөн нэвтрүүлгийн төв станцыг тоон радио технологид шилжүүлнэ.

МАЛ АЖ АХУЙ

Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, дэмжин хөгжүүлнэ.

Хөвсгөл аймагт мал, амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төв байгуулна.

ТЭЭВЭР ЛОГИСТИК, БООМТ

Ханх боомт-Хатгал тосгон болон Мөрөн хот-Тэлмэн сум чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын бүсэд ногдох хэсгийг барина.

Ханх, Бага-Илэнх боомтуудыг өргөжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Хөвсгөл аймгийн нисэх буудлыг 4С ангиллын болгон өргөтгөнө.

НИЙТ 12 ТӨСӨЛ

Үйлдвэр
үйлчилгээний

1

Хоёрдугаар үе шат
2025-2040 он

Соёл, аялал
жуулчлалын

2

Гуравдугаар үе шат
2025-2050 он

Шинжлэх ухаан,
технологт

3

Нэгдүгээр үе шат
2025-2030 он

Мал аж ахуй

1

Нэгдүгээр үе шат
2025-2028 он

Боловсрол,
эрүүл мэндийн


2

Нэгдүгээр үе шат
2025-2028 он

Тээвэр логистик,
боомтын

3

Хоёрдугаар үе шат
2024-2040 он





Иргэд, олон нийтийн санал

ХОЙД БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААН

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тэмдэглэл, 01 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар тэмдэглэл, Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бүсүүдийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ыг зохион байгуулах, бүсчилсэн хөгжлийн хөдөлгөөнийг өрнүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох байгууллагуудад даалгасан.

Эдгээр шийдвэрийн хүрээнд бүс бүрийн даргыг тухайн бүсийн аймгуудын Засаг дарга нар цагаан толгойн дарааллаар жил бүр ээлжлэн зөвлөлийг даргалах зохицуулалттай болсон. Бүсийн зөвлөлийн үндсэн зорилго нь бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжих, бүсийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, бүсийн түвшний төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, институтийн зохицуулалтыг бэхжүүлэхэд оршино. Зөвлөл нь тухайн бүсээс

сонгогдсон УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, сумдын ИТХ болон Засаг дарга нарын төлөөллөөс бүрдэнэ.

Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн удирдлагуудын шинэ бүрэлдэхүүн томилогдсонтой холбоотойгоор бодлого, шийдвэр гаргагчдын ойлголт, хандлагыг нэг мөр болгон уялдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүрээнд Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 28-нд Булган аймагт амжилттай зохион байгууллаа.

Бүсийн зөвлөлийн үйл



ажиллагааны хүрээнд бүсүүдийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулах, бүс бүрд хэрэгжүүлэх 5 тэргүүлэх төслийг тодорхойлох мөн “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгад санал өгөх ажлыг эхлүүлээд байна. Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан хөгжлийн бодлогын нэгдсэн ойлголтыг бүрдүүлэх, 2040 он хүртэлх хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, бүсийн түвшний төслүүдийг төр- хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх үндэс суурийг бататгах, бүсийн хөгжлийн үйл ажиллагааг нэгдсэн нэг бодлогын хүрээнд төлөвшүүлэхэд чиглэлээ.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан амжилттай боллоо. Энэхүү арга хэмжээ нь бүс нутгийн

ирээдүйн өнгө төрхийг тодорхойлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргасан бодит үр дүнтэй уулзалт болов.

Бүсчилсэн хөгжил бол зөвхөн цаасанд үлдэх өгүүлбэр биш, иргэдийн оролцоо дээр тогтох “хамтарсан үйл хэрэг” гэдгийг тус хуралдаан харуулаа. Нийт 1,201 оролцогч хүрэлцэн ирсний дотор төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөллүүд багтсан юм.

Хуралдааны уур амьсгал нээлттэй, шүүмжлэлтэй бөгөөд бүтээлч байв. Иргэдийн зүгээс 69 асуулт тавьж, цахимаар 131 санал ирүүлснийг холбогдох сайд нар газар дээр нь хариулан шийдвэрлэсэн нь төрийн үйлчилгээ иргэндээ ойртсоны илрэл байлаа. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр 571 гаруй контент түгээгдсэн нь энэхүү реформын ач холбогдлыг олон нийтэд таниулахад чухал үүрэг гүйцэтгэв.

Хойд бүс нь зөвхөн байгалийн

үзэсгэлэн төдийгүй эдийн засгийн асар их нөөцтэй гэдгийг арга хэмжээний үеэрх "Брэнд үзэсгэлэн" харуулсан бөгөөд 43 аж ахуйн нэгж өөрсдийн инноваци шингэсэн бүтээгдэхүүнээ танилцуулан 32 бизнес төсөл хөрөнгө оруулагчдад танилцуулагдан бүс нутгийн хөгжлийн хөдөлгүүр болоход бэлэн гэдгээ илэрхийллээ.

Засгийн газраас танилцуулсан хөгжлийн шинэ загварын гол үзэл баримтлал нь "Стандарттай хөгжил" юм. Энэ нь орон нутагт амьдарч буй иргэн бүр хотын иргэдтэй ижил түвшний үйлчилгээ авдаг, орлого олдог, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байв. Байгалийн баялгийн шударга хуваарилалт, хүн амын зохистой байршил, хувийн хэвшлийн итгэлийг сэргээх асуудлууд хуралдааны гол цөм байлаа.

Хуралдааны үр дүнг илтгэх гол үзүүлэлт бол бодит ажил хэрэг болохуйц хууль эрх зүйн баталгаа юм. Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх тухай, 209 дүгээр тогтоолоор Бүс нутгийн эдийн засгийн тулгуур болох "Үйлдвэрлэл, технологийн парк"-ийг байгуулах тухай тогтоолуудыг тус тус батлагдсан.

Эдгээр тогтоолууд хэрэгжсэнээр Хойд бүсийн гурван аймаг харилцан уялдаатай хөгжиж, улсын төсвөөс хараат бус, бие даасан эдийн засагтай "Хөгжлийн зангилаа" болох эхлэл тавигдаж байна.

Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаанаар "Шинэ итгэл, эрс шинэтгэл"-ийн уриаг бодит ажил болгож чадах стандарттай хөгжил, оролцоотой шийдэл, баталгаатай ирээдүйг бий болгох Хойд бүсийн шинэ дүр төрхийг тодорхойллоо.

ХОЙД БҮСИЙН ХӨГЖЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭР



Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 03 дугаар тэмдэглэл, 2025 оны 01 дүгээр сарын 22-ны хуралдааны 05 дугаар тэмдэглэл, Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар “Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг бүс бүрд зохион

байгуулж, бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүс тус бүрд шаардлагатай мега төслийг танилцуулж, хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Энэ хүрээнд “Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан”-ыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Булган аймагт зохион байгууллаа. Засгийн газрын өргөтгөсөн хуралдаанаар Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох шийдвэрүүдийг гаргасан.

Үүнд:

1. Засгийн газрын 2025 оны “Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоол;
2. Засгийн газрын 2025 оны “Хойд бүсэд үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих зарим хэмжээний тухай” 209 дүгээр тогтоол;
3. Засгийн газрын 2025.04.28-ны өдрийн 20 дугаар тэмдэглэл



ХОЙД БҮСИЙН ЗӨВЛӨЛИЙН

АНХДУГААР ХУРАЛДААНААС ГАРСАН
ГОЛЛОХ ШИЙДВЭРҮҮДИЙГ ХҮРГЭЖ БАЙНА

БУЛГАН АЙМАГТ


- Хойд бүсийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэр, технологийн паркийг Булган аймагт байгуулах
- Босоо тэнхлэгийн Бага-Илэнх боомт-Хутаг-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто замын төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
- Булган аймгийн Дашинчилэн-Өлзийт-Хайрхан-Рашаант-Мөрөн чиглэлийн авто замын барилгын ажлыг эрчимжүүлэх

ОРХОН АЙМАГТ

- “Эрдэнэт медиал” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв болгох
- Тээвэр, логистикийн төвийг Орхон аймагт байгуулах
- Орхон аймгийн Эрдэнэт хотод Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах

ХӨВСГӨЛ АЙМАГТ

- Бүгд Найрамдах Солонгос Улс-Хөвсгөл аймгийн Мөрөн сум чиглэлд олон улсын шууд нислэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлж, нисэх буудлыг 4С ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх
- Ханх-Монд боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг 2026 оны улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх
- Хөвсгөл аймгийн Мөрөн суманд хэрэгжүүлэх 50 МВт-аас доошгүй хүчин чадалтай дулааны цахилгаан станцын төслийн ТЭЗҮ боловсруулах




Засгийн газрын 2025.04.28-ны өдрийн 20 дугаар тэмдэглэл

1. “Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025 оны 204 дүгээр тогтоол

2. “Хойд бүсэд үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих зарим хэмжээний тухай” 2025 оны 209 дүгээр тогтоол

45 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТУСГАГДАВ

Бүсэд УТП-ийн хөгжлийг дэмжих хүрээнд-	3
Бүсийн эрчим хүч, зам, дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд	20
Бүсийн боловсрол, эрүүл мэнд, бизнесийн хөгжлийг дэмжих хүрээнд	10
Бүсийн соёл, аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд	6
Бүсийн байгаль орчныг хамгаалах, ХАА, үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд	3
Бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд	3



БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” нь Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)-ын эрхлэх асуудлын хүрээнд үүсгэн байгуулагдсан.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үндэсний соёлоо дээдэлсэн, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, хүн амын нутагшилт суурьшлын тогтвортой, тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүсийг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлнэ.



"Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн"-гийн хамт олон

ХҮРЭЭЛЭНГИЙН ЧИГ ҮҮРЭГ

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч байгууллага, салбарын үйл ажиллагааны уялдааг хангах, шинжлэх ухааны үндэслэлтэй дэмжлэг, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

ХҮРЭЭЛЭН НЬ ДООРХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ДАРААХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон холбогдох бусад байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулахад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын хувилбар судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, цахим мэдээллийн сан бүрдүүлж, эрхлэн хөтлөх, мэдээлэх;

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд батлагдах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, бодлого, төлөвлөлтийн нийцэл, уялдааг хангах чиглэлээр санал хүргүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хариуцан хэрэгжүүлэх;

Бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжиж буй урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үр дүнд үндэслэн цаашид төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах, хөрөнгө болон хүний нөөцийн талаар санал гаргаж холбогдох байгууллагад уламжлах;

Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бүсчилсэн хөгжлийн талаар үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгч Монгол Улсын Шадар сайдад тайлагнах;

Бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэхэд холбогдох бодлогын судалгаа төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

Бүсчилсэн хөгжлийн бодлого, хэрэгжилтийн талаар олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг эрхлэн явуулах юм.